

**“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023.04.29

Дугаар 01

Улаанбаатар хот

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Махатма Гандийн гудамж 39, Корпорэйт конвеншн центрийн “Эвэнт холл” танхимд 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагаас хосолсон хэлбэрээр танхимаар 113, зайнаас 36 нийт 149 хувьцаа эзэмшигчдийн 95.08 хувийн ирцтэйгээр эхлэв.

Хурлын дарга:

С.Мөнгөнчимэг – Сангийн дэд Сайд

Хуралд оролцсон:

Б.Тэлмүүн- ТУЗ-ийн дарга
Г.Золбоо – ТУЗ-ийн гишүүн
М.Батжаргал -ТУЗ-ийн хараат бус гишүүн
Д.Энхжаргал - ТУЗ-ийн хараат бус гишүүн
С.Цэнд-Аюуш - ТУЗ-ийн хараат бус гишүүн

Хурал зохион байгуулах комисс

Комиссын дарга:

Д.Сугар – Тэргүүн дэд захирал

Комиссын орлогч дарга:

Э.Хангай – Засаглалын албаны ахлах хуульч

Комиссын гишүүд:

Э.Уянга – ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Д.Баттулга – Дэд захирал
Б.Амарсанаа – Хуулийн газрын захирал
Г.Энхтамир – МТГ-ын захирал
Г.Содонбаатар – МОНХГ-ын захирал
О.Баасансүрэн – АААБГ-ыг захирал
Н.Энх-Амгалан – ДАГ-ын МТАТХ-ийн захирал
Г.Баясгалан – Засаглалын албаны ахлах мэргэжилтэн
С.Оюун-Эрдэнэ – ХЗГ-ын дилер

Комиссын нарын бичгийн дарга:

Хурлын тооллогын комисс

Комиссын дарга:

А.Батмөнх – ДХШГ-ын захирал

Комиссын гишүүд:

Ц.Дамдинсүрэн – ЭУГ-ын захирал
Д.Жадамбаа – ХЗГ-ын захирал
Б.Цэндсүрэн – МТГ-ын ХХ-ийн захирал
Л.Булгаа – ХҮА-ны менежер

Комиссын нарийн бичгийн дарга:

ХЭЛЭЛЦСЭН нь:

ТАНИЛЦАХ АСУУДАЛ:

1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
2. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга;
3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаарх танилцуулга;

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл;
2. “Төрийн банк” ХК-ийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай тогтоолын төсөл;
3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл;
4. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батлах тухай тогтоолын төсөл;
5. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажиллах журам батлах тухай тогтоолын төсөл.

СОНССОН нь:

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Сайн байцгаана уу. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танхимаар болон цахимаар оролцож буй нийт хувьцаа эзэмшигч нартаа энэ өдрийн мэндийг хүргэе. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны бүртгэлийн өдрөөр тасалбар болгон ҮЦТХТ-өөс тархалтын мэдээгээр “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн эзэмшиж буй хувьцааны хувийг танилцуулбал, Сангийн яам 49.26 хувь, ХДК 45.3 хувь, олон нийт 5.71 хувийг тус тус эзэмшиж байна. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны 41 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Тооллогын комиссын дарга А.Батмөнх миний бие Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ирцийн тогтоолыг та бүхэнд танилцуулъя. Тус тогтоолыг танилцуулахаас өмнө хурлыг удирдан зохион байгуулах Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Тэлмүүн, Гүйцэтгэх захирал Ө.Гантөр та бүхнийг тайзнаа урьж байна. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр, дугаар 1. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүчин төгөлдөр болсныг батлах тухай. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн тогтоох нь, “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй нийт 755,096,250 ширхэг хувьцаанаас тус хуралд саналын эрх бүхий 717,947,864 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноор, нийт саналын эрхтэй хувьцааны 95.08 хувь болж Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

Тооллогын комиссын дарга А.Батмөнх, гишүүд Ц.Дамдинсүрэн, Д.Жадамбаа, Б.Цэнд-Сүрэн, нарийн бичгийн дарга Л.Булгаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааг албан ёсоор удирдан нээж өгнө үү, хэмээн Сангийн дэд Сайд Санжаагийн Мөнгөнчимэг таныг микрофонд урьж байна.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Эрхэм хувьцаа эзэмшигч хатагтай, ноёд, Төрийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн мөн цахимаар оролцож байгаа хүндэт зочид Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс Засгийн газраас 14 жилийн өмнө “Төр” гэсэн ганцхан хувьцаа эзэмшигчтэй байгуулж байсан банк маань бүл нэмж өдгөө нийт 7653 хувьцаа эзэмшигчтэй болсон. Төрийн Банк нь банкны салбарын зохистой бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн, Монгол Улсын банкны салбарын ТОП 5 банкны нэгээр дахин шалгарч, амжилтаа баталгаажуулсан бөгөөд Монголбанкны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажиллаж байгаа нь банкны үйл ажиллагаа жигд өсөлтийг ханган ажиллаж байгааг харууллаа. Өнгөрсөн жилүүдэд банк, санхүүгийн салбарт тулгарсан эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдал, аюулт цар тахал зэрэг хүчин зүйлээс хамаарсан олон сорилт, шалгуурыг эвийн хүчээр хамтдаа туулж, бүх түвшинд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд санхүүгийн эерэг үзүүлэлтүүдийг үзүүлж, банк санхүүгийн системд эзлэх байр сууриа хамгаалан ажилласан системийн нөлөө бүхий банкны хувьцаа эзэмшигч Та бүхэнд хувиасаа болон Засгийн газрын нэрийн өмнөөс талархал илэрхийлж, ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ, Төрийн банк нь цаашид дунд хугацаанд буюу 2023-2025 онд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэн, нийгмийн дундаж давхаргыг дэмжих, жижиг дунд бизнесийг хөгжүүлэх, өрхийг орон сууцжуулах, барилгын салбарын ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн, байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, олон улсын жишигт нийцсэн санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэгч Үндэсний тэргүүлэгч банк байх зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна. Цаашид, Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас төрийн өмчит компаниудын талаар баримталж буй бодлогыг бодитойгоор хэрэгжүүлэх зорилтын хүрээнд компанийн засаглал, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны хяналт, ил тод байдлыг сайжруулахтай холбоотой сайн туршлагыг нэвтрүүлж ажиллах бөгөөд үүнд иргэд, олон нийтийн оролцоо туйлын чухал болохыг энд цохон тэмдэглэх нь зүйтэй юм. Энэ хүрээнд бид тэргүүн ээлжид хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлсэн банк байхаас гадна олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх үүднээс нийт хувьцааны 20 хүртэлх хувийг биржээр дамжуулан олон нийтэд арилжаалах ажлыг үе шаттайгаар хамтран зохион байгуулж чадна гэдэгт итгэлтэй байна. Монгол Улсын банк, санхүүгийн салбарт олон жилийн хүлээлт үүсгэсэн түүхэн арга хэмжээг хамтран амжилттай хэрэгжүүлсэн явдлын түүхэн гэрч болсон эрхэм хувьцаа эзэмшигч Та бүхэндээ дахин халуун баяр хүргэж, ажил, амьдралын зам мөрөө холбосон хувьцаа эзэмшигч Та бидний ашиг, орлого улам бүр арвижиж, ажил үйлс бүхэн тань өргөжин хөгжихийн ерөөл дэвшүүлье. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагааг нээснийг үүгээр мэдэгдье. Хувьцаа эзэмшигч Та бүхэн өнөөдрийн хуралд идэвхтэй оролцож, Та бүхний санал бодол, зөвлөмж банкны үйл ажиллагааг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэхэд ихээхэн том хувь нэмэр болно гэж бодож байна. Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа. Хурлын хөтөлбөр танилцуулахаас өмнө ТУЗ-ийн дарга, гишүүд, банкны удирдлагын баг хамт олныг тайзан дээр урья. Жил болгон 4 сард компаниуд хувьцаа

эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулдаг уламжлалтай байдаг. Өнөөдөр Төрийн банкны хувьцаа эзэмшигчдийн хурлыг Та бид хийх гэж байна. Хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангахын тулд амралтын өдрийг сонгон авч зохион байгуулж байна. Та бүхэнд урьдчилаад хурлын материал хүргэгдсэн учраас урьдчилан танилцсан байх гэж бодож байна. Дэлгэц дээр хурлын хөтөлбөр гарсан байна. Хурлын хөтөлбөрт нийт танилцах 3 асуудал, хэлэлцэх 5 асуудал байгаа. Хэлэлцэх 5 асуудал болгонд санал хураана. Тус бүр дээр хурлын шийдвэр буюу тогтоол гарч баталгаажуулна. Эхлээд танилцах 3 асуудалтай танилцаад, дараа нь хэлэлцэх 5 асуудалдаа ороод явна. Танилцах асуудлын хувьд 1 дүгээрт Төрийн банкны 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, 2 дугаарт, Ногдол ашиг хуваарилах талаарх танилцуулга, 3 дугаарт Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулалтын талаар танилцуулна. Хэлэлцэх асуудлын хувьд 1 дүгээрт компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батална. 2 дугаарт, “Төрийн банк” ХК-ийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай асуудал дээр шийдвэр гарна. 3 дугаарт, “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулна. 4 дүгээрт, “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батална. 5 дугаарт, “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам батална. Дэлгэц дээр хурлын дэг гарсан байна. Та бүхэнд цаасаар тарааж өгсөн байгаа. Хурлын дэг өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагаа болон асуулт хариулт ямар хэлбэрээр явагдах, хурлын шийдвэр хэрхэн гарах талаар тусгасан байгаа. Энэ хурлын дэг болон хурлын хөтөлбөрөө гар өргөж баталгаажуулаад хурлын үндсэн үйл ажиллагаандаа ороод явъя.

Цэрэнжав, Хувьцаа эзэмшигч: Хурлын материал зарласны дагуу 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар брокер дилерийн компаниар таарагдсан байх ёстой. Харамсалтай нь 18, 19-н хүртэл тараагдаагүй. Би өөрөө Төрийн банк дээр очиж хэвлэмэл материал авч танилцсан. Хугацаандаа материал тараагдаагүй учраас энд байгаа хувьцаа эзэмшигч нар хугацаандаа материал аваагүй гэж бодож байна. Хэлэлцэх асуудал дотор ТУЗ-ийн зохион байгуулалтын асуудал дурдагдаагүй байна. Бид хувьцаа эзэмшигч болоод 4,5 сар боллоо. Ямар ТУЗ-өөр удирдуулаад, хэн гэж хүн байгааг харж мэдмээр байна. Нэг бүрчлэн танилцуулахгүй юу? Энэ хуралд зохион байгуулалтын асуудал орохгүй юм уу? Төрийн банк компанийн тухай хуулиар анх удаа ээлжит хурал хийж байна. Тиймээс энэ асуудал хөндөгдөх болов уу гэж бодож байна.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Төрийн банкны ТУЗ нь 3 дугаар сарын 17-ны өдөр хурлаа хийж, хувьцаа эзэмшигчдийн хурлаа энэ өдөр буюу 4 сарын 29-ний өдөр зарласан. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулах, хэлэлцүүлэх нийт 8 асуудал дээр орно гээд шийдвэр гарсан. Үүний дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал хөтөлбөрийн дагуу явна. Хувьцаа эзэмшигчдийн хурал Компанийн тухай хууль, дүрэм журмын хүрээнд явагддаг. Тэгэхээр хэлэлцэх асуудлын хүрээнд хурлын үйл ажиллагаа явна. Тиймээс таны асууж байгаа ТУЗ-ийн зохион байгуулалтын асуудал, өнөөдрийн хурлын хэлэлцэх асуудалд байхгүй байгаа. Харин ТУЗ-ийн ажиллах журам өнөөдрийн хэлэлцэх асуудалд ороод явна. Хурлын материалыг цаг хугацаандаа тараагаагүй гэж байна. Үүн дээр Гүйцэтгэх захирал Ө.Гантөр тайлбар өгнө үү.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Юуны өмнө хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. “Төрийн банк” нь ХК болоод ээлжит хурлыг анх удаагаа хийж байна. Ээлжит бус хурлыг 2022 оны 12 дугаар сард хийгээд хэлэлцэх асуудлуудыг батлаад явсан. ТУЗ-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийн дагуу холбогдох

материалыг цаасаар болон цахимаар цаг хугацаандаа холбогдох брокер дилерийн компаниудад тараасан. Зарыг 2 удаа явуулсан. Мөн өөрийн банкны вэбсайт дээр холбогдох мэдээллүүдийг нээлттэй тавьсан ба материал хуулийн хугацаандаа тараагдсан байгаа.

Энхбаяр, Хувьцаа эзэмшигч: Энэ асуудал дээр ТУЗ-ийн дарга тайлбар өгвөл яасан юм бэ? ТУЗ-ийн зохион байгуулалтын асуудлыг яагаад энэ хурлаар хэлэлцэхгүй байгаа юм бэ? Хувьцаа эзэмшигч болоод 5,6 сар болсон учраас, хувьцаа эзэмшигч эрхээ хэрэгжүүлж ТУЗ-ийн гишүүдээ сонгомоор байна шүү дээ. Яагаад энэ асуудлыг дурдахгүй, ТУЗ-ийн зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэхгүй байгаа юм бэ?

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Төрийн банк олон нийтэд нээлттэй болсон учраас засаглалын хувьд нээлттэй болох нь зөв, зарчмын хувьд дэмжиж байгаа. ТУЗ-ийн бүрэлдэхүүн ердийн гишүүн 6, хараат бус гишүүн 3, буюу нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй. Бид төрийн төлөөллийн ТУЗ-ийн гишүүдийг аль болох бууруулаад, олон нийт буюу 5.71 хувийн хувьцаа эзэмшигчдээс төлөөллийн оролцоог хангах үүднээс тодорхой ажлуудыг авч хэрэгжүүлээд явна. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд олон нийтийн төлөөлөл 1 хүнийг оруулах зохион байгуулалтын ажил хийгдээд явахаар байгаа.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Та бүхний өглөөний амгаланг айлтгая. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай хуулийн нарийн зохицуулалтууд байдаг. ТУЗ тодорхой хэмжээний бүрэн эрхийн хүрээнд тогтоол гаргаж байгаа. Үүнтэй холбоотой хувьцаа эзэмшигчээс тодорхой чиглэл авдаг. Үүний дагуу 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 41 дүгээр тогтоол гарсан. ТУЗ-ийн гишүүнийг томилох, чөлөөлөх асуудал ТУЗ өөрөө бүрэн эрхийн дагуу шийдвэрлэдэггүйг Та бүхэн мэдэж байгаа байх. Банкны тухай хуулийн дагуу, Монголбанк мөн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа Сангийн яам болон ХДК-аас энэ асуудлаар удирдамж, чиглэл өгдөг. Сая хурал даргалагчийн хэлж байгаагаар, одоо төрийг төлөөлж байгаа нэг гишүүн чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн. Үүнтэй холбоотой тухайн гишүүний оронд Төрийн төлөөллийг оруулахгүйгээр хараат бус, жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг нэмж оруулах асуудлыг тусгайлан шийднэ. Тэгэхээр үүн дээр нээлттэй сонгон шалгаруулалт явна гэж ойлгох нь зүйтэй байх.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчийн асуултад хариулт өглөө. Одоо хурлын хөтөлбөрийн дагуу хурлын үндсэн үйл ажиллагаандаа орёе. Эхний танилцах асуудал буюу “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулгыг хийнэ үү, хэмээн Төрийн банкны Гүйцэтгэх захирал Ө.Гантөрийг индэрт урьж байна.

1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төрийн банк 2009 онд үүсгэн байгуулагдсан ба 14 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Төрийн банкны бүтэц зохион байгуулалтын хувьд Газар-16, Хэлтэс-20, Алба-7, Улаанбаатарт-82, Орон нутагт-413 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Онцлог үйл явдлаас дурдахад 2022 онд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт амжилттай шилжиж, Топ 100 аж ахуй нэгжээс 8 дугаарт, банкны салбарын шилдэг 4 банкны нэгээр дахин шалгарч, хурдан системийг нэвтрүүлж, PCI-DSS онсайт аудитыг ажилттай хийлгэсэн байна. Төрийн банкны 2022 оны бизнес төлөвлөгөө Стратегийн тэргүүлэх 3 чиглэлийн дагуу 21 үндсэн зорилт дэвшүүлж, 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 92

хувь буюу хангалттай үнэлгээтэй ажилласан. Санхүүгийн үзүүлэлтийн хувьд Төрийн банк сүүлийн гурван жилд нийт активаа дунджаар 8.1 хувиар нэмэгдүүлсэн. Банкны активын өгөөж 2022 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.35 нэгж хувиар өсөж 2.57 хувьд хүрсэн. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө тогтмол нэмэгдэж буй нь банкны үйл ажиллагаа өргөжин тэлж, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж байгааг илэрхийлж байна. 2022 онд нийт давхардсан тоогоор 1,184,067 харилцагчдад 1,877.2 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Төрийн банкны сүүлийн гурван жилийн дундаж цэвэр ашгийн өсөлт 71 хувь байна. Банкны өөрийн хөрөнгийн өгөөж 2022 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.87 нэгж хувиар өсөж 22.97 хувьд хүрсэн. Банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хувьд өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцааг тогтмол ханган ажиллахын зэрэгцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг биелүүлэн ажиллаж байна. Монголбанкны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажилласан төдийгүй бүлгийн дундажтай харьцуулсан үзүүлэлтүүд дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна. Тайлант хугацааны турш Банкны захирлууд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгосон нийт олговор Грант Торнтон Аудит ХХК-ийн хөндлөнгийн аудитаар Цалин ба бусад тэтгэмж 790.8 сая төгрөг нийгмийн даатгалын шимтгэл 158.7 сая төгрөг, Бонус болон бусад тэтгэмжүүд 487.2 сая төгрөгийн дүнтэй байна. 2022 онд Эрсдэлийн сангаар хорогдуулсан актив нийт 10 төлбөр хариуцагчид хамаарах 58,431,960.35 төгрөгийн үлдэгдэлтэй чанаргүй активыг зээлд учирч болзошгүй эрсдэлийн сангаас хорогдуулан бүртгэж, 3 зээлдэгчид хамаарах 2,689,393.00 төгрөгийн активыг төлүүлсэн. Дундаж давхаргыг дэмжигч банк болох зорилтын хүрээнд Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр Эрүүл иргэн хадгаламж, Сургалтын хадгаламж, Таван эрдэнэ малчны хадгаламж, зээлийн бүтээгдэхүүний хувьд Өрхийн бизнесийн зээл, Гарааны бизнесийн зээл, Боловсролыг дэмжих зээл, багц бүтээгдэхүүний хувьд Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдэд зориулсан багц бүтээгдэхүүн, Худалдааны зээлийн шугамын багц бүтээгдэхүүн үйлчилгээ зэрэг бүтээгдэхүүнийг тус тус гаргасан. Бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хосолсон валюттай виза карт, Миний монгол виза карт гаргаж цахим болон бусад үйлчилгээг идэвхжүүлэн ажилласан. Санхүүгийн боловсрол мэдээлэл өгөх чиглэлээр Инкубатор төвөөр дамжуулан харилцагч бизнес эрхлэгч нарт холбогдох сургалтуудыг хийж ажилласан. Төрийн банк Тогтвортой хөгжлийн хороо болон Тогтвортой хөгжлийн албыг шинээр байгуулж, Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэн ажиллаж байна. Тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийн үнэлгээг “Төрийн банк” ХК нь 2022 онд өмнөх оны үр дүнгээ ахиулан А буюу Хангалттай үнэлгээ авсан. “Төрийн банк” нь хувьцаа гаргаж татан төвлөрүүлсэн 25.4 тэрбум төгрөгийг Тогтвортой хөгжилд чиглэсэн, Нийгмийн дундаж давхаргад чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг санхүүжүүлэхэд зарцуулсан. Нийт 568 эмэгтэй бизнес эрхлэгчид 12.5 тэрбум төгрөгийн зээл олгосон. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан аяллын Save green кредит картыг зах зээлд нэвтрүүлсэн. Нийгмийн хариуцлагын хүрээнд Хүндэтгэлийн аян 2022 аян зохион байгуулж, Оюунлаг залуусаа дэмжих аяны хүрээнд Монголын шатрын холбоо, Шатрын их мастер, Монгол Улсын Гавьяат тамирчин Ц.Батчулуун, Дэлхийн 3 удаагийн аварга, өсвөрийн шатарчин Д.Мөнхзултай хамтран ажиллаж байна. Мөн бүх нийтээр мод тарих үндэсний өдөрт Төрийн банк нэгдсэн. Байгальд ээлтэй гялс цэвэрлэгээ аяныг Монгол Улсын 21 аймаг, 315 сум, Улаанбаатар хотын Туул Сэлбийн голын сав газар, орон нутагт тухайн аймаг, сумын гол горхи, ундны усны сав газар зэрэг нийт 6000 орчим га газрыг цэвэрлэж 735 тонн, ойролцоогоор 400 орчим автомашин хог хаягдлыг цуглуулах зэрэг ажлуудыг зохион байгуулан ажилласан. Ингээд ТУЗ-ийн үйл ажиллагааны товч танилцуулгыг ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн танилцуулна.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Та бүхэнд танилцуулъя. ТУЗ нь 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар байгуулагдсан. ТУЗ-ийн дарга миний бие Б.Тэлмүүн, Сангийн яаманд 13 дахь жилдээ ажиллаж байгаа. Санхүүч, эдийн засагч, Олон улсын эрх зүйч мэргэжилтэй. Ердийн гишүүн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Б.Ганбат. ЗХУ-ын Дотоод явдлын яамны Академийн хууль эрх зүй бакалавр, ИБУИНВУ-ын Коммонвелт хуулийн коллежид Хууль эрх зүйн магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. Сангийн яам, Монголбанкны Хууль эрх зүйн газрын даргаар ажиллаж байсан Төрд 30-аад жил ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат хуульч хүн байдаг. Ердийн гишүүн Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хууль, эрх зүйч бакалавр, АНУ-ын Калифорнийн Беркли их сургуулийн Хуулийн сургуулийн хууль эрх зүйч магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 2010-2022 онд хуулийн фирмд хуульч, ахлах хуульч, Ерөнхийлөгчийн тамгын газарт Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөхийн туслах, Хууль зүй, дотоод хэргийн яаманд Сайдын зөвлөхийн туслах, мэргэжилтэн, шинжээч, газрын даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай. Ердийн гишүүн Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир. МУИС-д эдийн засгийн математик загварчлалын бакалавр, Австралийн Холбооны Улсын Сиднейн их сургуулийн эдийн засгийн онолын магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 2005-2022 онд Сангийн яамны Төрийн сангийн газар, Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газарт мэргэжилтэн, хэлтсийн дарга, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн даргаар тус тус ажилласан туршлагатай. Б.Сүх-Очир гишүүн ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн. Энэ хүний оронд Төрийн төлөөллийг нэмж оруулахгүй хараат бус, олон нийтийн төлөөллийг нэмж оруулах чиглэлтэй байгаа. Ердийн гишүүн Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн банкны эдийн засагч бакалавр, ИБУИНВУ-ын Уельсийн их сургуулийн олон улсын бизнесийн менежментийн чиглэлээр боловсрол эзэмшсэн. 2013-2022 оны хооронд Сангийн яаманд зөвлөх, хэлтсийн дарга, газрын даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай. Ердийн гишүүн Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Л.Сонор. АНУ-ын Такома коммюнити коллежийн Бизнесийн удирдлага, АНУ-ын Вашингтоны их сургуулийн Санхүү, бизнесийн удирдлагын бакалавр зэргээр боловсрол эзэмшсэн. 2015-2022 онд Сангийн яаманд Санхүүгийн бодлогын газарт зөвлөх, мэргэжилтэн, хэлтсийн даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай. Мөнгө угаах терроризмын санхүүжилттэй тэнцэх Монголын ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажилладаг. Хараат бус гишүүн Монгол Улсын гавьяат эдийн засагч М.Батжаргал. Хөдөө аж ахуйн дээд сургуулийг эдийн засагч бакалавр, эдийн засгийн ухааны магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 1975-1989 онд Улсын банканд эдийн засагч, орлогч дарга, Увс аймгийн Арбитр - Ерөнхий арбитрч, 1993-2008 онд Монголбанканд газрын захирал, ерөнхий захирал, ахлах ажилтан, ахлах хянан шалгагч, Хяналт шалгалтын хэлтсийн захирал, Дотоод аудитын газрын ахлах хянан шалгагч, аудитын зөвлөхөөр тус тус ажилласан ажлын туршлагатай. Хараат бус гишүүн Д.Энхжаргал. ОХУ-ын Эрхүүгийн улс Ардын аж ахуйн дээд сургуулийн Санхүү банкны эдийн засагч бакалавр, АНУ-ын Вандербилдын их сургуулийн Эдийн засгийн хөгжлийн магистр, ИБУИНВУ-ын Сити их сургуулийн судлаач докторант, Лондонгийн их сургуулийн судлаач докторантын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 1986-1991 онд Улсын банкны Ерөнхий хороонд зээлийн эдийн засагч, 1991-2015 онд Монголбанканд эдийн засагч, газрын захирал, Ерөнхий эдийн засагч, Ерөнхийлөгчийн зөвлөх, Дэд ерөнхийлөгч, Лондон дахь Монголбанкны Төлөөлөгчийн газрын захирал, Санхүүгийн

хөгжлийн стратегийн зөвлөхөөр тус тус ажилласан ажлын туршлагатай. Хараат бус гишүүн Монгол Улсын гавьяат эдийн засагч С.Цэнд-Аюуш. Санхүүч, ОХУ-ын Эрхүү хотын Улс Ардын Аж Ахуйн дээд сургуульд санхүүч бакалаврын зэргээр боловсрол эзэмшсэн. 1978-2015 онд Сангийн яаманд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар мэргэжилтэн, ахлах мэргэжилтнээр тус тус ажилласан ажлын туршлагатай. ТУЗ-д гавьяат эдийн засагч-2, Гавьяат хуульч-1 байдаг. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд Хууль зүй, Хөрөнгө оруулалт, Эрсдэл, Мөнгө угаах, Татвар, Санхүүгийн мэргэжлийн хүмүүс байдгаараа онцлогтой. ТУЗ нь 2022 онд ээлжит болон ээлжит бусаар 19 удаа хуралдаж, 78 асуудал хэлэлцэн 35 шийдвэр, 110 тогтоол батлан ажилласан. ТУЗ-ийн тогтоол шийдвэрийн биелэлт 94.2 хувьтай байна. 2022 онд голлон анхаарч хэрэгжүүлсэн ажлаас дурдвал Хувьцаа эзэмшигч, харилцагчийн эрх ашгийн хамгаалах, урт хугацаанд тогтвортой байлгах чиглэлийг баримтлан Төрийн банкны 2023-2025 оны Дунд хугацааны стратеги төлөвлөгөө болон Бизнес төлөвлөгөөг банкны алсын хараанд нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан. Банкныг олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх шийдвэрүүдийг шуурхай гаргаж, анхдагч зах зээлийн арилжаа 304.66 хувийн биелэлттэйгээр арилжаалагдаж, 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдөр “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурлыг зохион байгуулсан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд санхүүгийн сахилга бат, төсвийн хэмнэлтийн горимыг баримтлан ажилласны үр дүнд 2022 онд 18.3 тэрбум төгрөгийг хэмнэн, банкны ашигт ажиллагаанд эергээр нөлөөлсөн. Банкны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, Олон улсын зах зээлээс хөрөнгө оруулагчдыг татах, ногоон зээлийн багцын өсөлт бий болгох, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, банканд байгаль орчин, нийгэм, зохистой засаглалын олон улсын туршлагыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогыг батлан хэрэгжүүлж эхлээд байна. Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавьж, гүйцэтгэх удирдлагаас эрсдэлийн удирдлагын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээлэл, үр дүнтэй Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хороо болон Төлөөлөн удирдах зөвлөл танилцан ажиллаж байна. ТУЗ-ийн дэргэд Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо ажилласан. Хороодын даргаар хараат бус гишүүд ажилладаг. Дэргэдэх хороод 2022 онд 13 удаа хуралдаж, 37 асуудал хэлэлцэн нийт 24 шийдвэр гаргав. ТУЗ-ийн гишүүд хүрэлцэн ирсэн байгаа тул Та бүхэн асуух асуулт байвал нээлттэй асууж болно. 2023 онд нийт 4 хороотой болсон. Хороодын бүрэлдэхүүний 50-иас дээш хувийг хараат бус гишүүд бүрдүүлнэ. Эрсдэлийн удирдлагын хорооноос бусад хороодын даргаар хараат бус гишүүд ахлаад ажиллаж байгаа. Бид аль болох хараат бус гишүүд, олон нийтийн оролцоотой, Төрийн төлөөллийн оролцоог бууруулах чиглэлээр удирдан зохион байгуулж байгаа. Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Өнгөрсөн оны үйл ажиллагаа, Санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал Ө.Гантөр, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ТУЗ-өөс хийж хэрэгжүүлсэн ажил, шийдвэрүүдийн талаар ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн танилцууллаа. Баярлалаа. Дараагийн 2 дахь танилцуулах асуудалдаа оръё. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай танилцуулгыг мөн ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн танилцуулна.

2. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Төрийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай танилцуулгыг хийв.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Б.Тэлмүүн даргад баярлалаа. Танилцуулах 3 дахь асуудалдаа оръё. 2022 оны 12 сард Төрийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хийсэн. Тухайн хурлаар 3 асуудал хэлэлцсэн. Үүний нэг асуудал болох олон нийтийн оролцоо хяналтыг бий болгох зорилгоор Хяналтын зөвлөл байгуулах, Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг баталсан. Хяналтын зөвлөлийн сонгон шалгаруулалтыг жижиг хувьцаа эзэмшигчдээс бүрдүүлэхийг ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороонд чиглэл өгсөн. Энэ талаарх танилцуулгыг нэр дэвшүүлэх хорооны дарга ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Энхжаргал танилцуулна. Таныг индэрт урьж байна.

1. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаарх танилцуулга

Д.Энхжаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүн Нэр дэвшүүлэх хорооны дарга: “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаарх танилцуулгыг хийв.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Д.Энхжаргал гишүүнд баярлалаа. Хяналтын зөвлөлийн ажиллах журамд заасан Хяналтын зөвлөлийг байгуулах үндэслэл, нөхцөл энэ удаад бүрдээгүй байна гэж танилцууллаа. Нөхцөл бүрдээгүй учраас энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Хяналтын зөвлөлийг байгуулах боломжгүй болсон байна. Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудалд Хяналтын зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал байгаа. Үүн дээр тодорхой асуудлууд яригдаад явна. Хурлын хөтөлбөрийн дагуу танилцуулах 3 асуудал танилцуулагдлаа. Үүнээс хойш өнөөдрийн хурлаар хэлэлцэх 5 хэлэлцэх асуудалд орно. Хэлэлцэх асуудал болгоны ард хувьцаа эзэмшигчдээс асуулт, хариулт авна. Хэлэлцэх 5 асуудлын хүрээнд саналт хураалт хэрхэн явах, саналаа хэрхэн өгөх талаар тооллогын комисс тайлбарлана. Тооллогын комиссын дарга А.Батмөнх таныг индэрт урьж байна.

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Хурлаар хэлэлцэх асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Хэлэлцэх эхний асуудалдаа оръё. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийн танилцуулгыг ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийн танилцуулгыг хийв.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Б.Тэлмүүн даргад баярлалаа. Хурал дэгийн дагуу явагдана. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой Та бүхэн 2 минутад багтааж асуултаа асууна. Хариулт аль болох товч тодорхой байх тал дээр анхаарч ажиллана. Таны асуух асуултад ТУЗ-ийн дарга, гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ, Төрийн банкны Гүйцэтгэх захирал Ө.Гантөр, удирдлагын багын хамт бүрэн бүрэлдэхүүнээрээ хариулна. Хурлын тэмдэглэл явагдаж байгаа учраас хувьцаа эзэмшигч Та нэрээ хэлээд асуугаарай. Өнөөдрийн хурал танхимаар болон

цахимаар болж байгаа. Эхлээд танхимаас асуултаа аваад, дараа нь цахимаар оролцож байгаа хүмүүсийн асуултыг аваад явъя. Энэ асуудалтай холбоотой асуулт хариулт руугаа оръё.

Жавхлан, Хувьцаа эзэмшигч: МУИС-ийн нягтлан бодох бүртгэлийн докторант. Гүйцэтгэх захирал Ө.Гантөр танаас асууя. Банкны системд Төрийн банкныг бат гэж ойлгодог. Монгол Улсад ШШ ажиллагааны хүрээнд маш их авлага хуримтлагдана. Гэтэл Төрийн банкны маш үр өгөөжтэй ажилладаг касс Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт байхгүй болсон байна. Одоогийнх байдлаар тэнд Голомт банк, ХХБ ажиллаж байгаа. Банк үүн дээр үр өгөөжийн талаар тооцоо хийсэн үү? Кассыг эргүүлэн ажиллуулах боломжтой юу? Төрийн банкны теллер харилцагчийн үйлчилгээний ажилтныг зөвхөн орлого зарлага, гадаад төлбөр тооцоо, зээлийн талаар мэдээлэлтэй биш, шүүхийн улсын тэмдэгтийн хураамж үүсгэх, татвар зэрэг олон асуудлуудыг мэддэг учраас том боловсон хүчин гэж ойлгодог. Тэгэхээр энэ 4000 ажилтнуудыг цаашид үнэлгээчний эрх, брокер дилерийн эрх, мэргэшсэн нягтлангийн эрх, мэргэшсэн татварын зөвлөхийн эрх, зэргийг оруулбал 4,000 гаруй ажилтнууд хувьцаа эзэмшигч болоод хувьцааны эрэлтийг нэмэгдүүлэх юм биш үү. Гэсэн асуулт болон саналтай байна. Би яагаад МУИС-ийг тодотгож хэлээд байна вэ, гэхээр биллингийн системээр судалгааны ажил бичиж байгаа гэж өмнөх Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал дээр хэлж байсан. Цаашид үндэсний үйлдвэрийг дэмжин биллер байгууллага буюу танай биллер үйлчилгээ гэж оруулах уу? E-Mongolia дээр и-биллинг гэж оруулах уу?

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Асуултын харилтыг Гүйцэтгэх захирал Ө.Гантөр өгнө үү.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төрийн банк 4000 гаруй ажилтантай. 500 орчим нэгж салбартай. Бид бүхэн тухайн аймаг орон нутаг дээр зах зээлийн багтааж, үр өгөөжийн тал дээр судалгаа хийж, нэгжийг шилжүүлж шинээр нээх ажлуудыг хийдэг. ШШГЕГ-т өмнө нь касс ажиллаж байсан. Кассын хувьд нэлээдгүй олон жил үр ашигтай ажилласан. Яг хажууд нь манай тээврийн товчоо тооцооны төв ажиллаж байгаа учраас кассыг татсан байгаа. Мэдээж ашигтай газарт нэгж нээх чиглэлийг баримтлан ажиллаж байгаа. Ажилтнуудыг мэргэшүүлэх талаар хэлж байгаа таны санал маш зөв асуудлыг хөндөж байна. Хүний нөөцийн бодлогын хувьд ажилтнуудаа сургалтад суулгах, мэргэшүүлэх тал дээр өдөр болгон хичээж ажиллаж байгаа. Банканд мэргэшсэн теллер, нягтлан бодогч, хуульч, аудиторууд ажиллаж байгаа. Цаашид ажилтнуудаа мэргэшүүлэх тал дээр анхаарч ажиллана.

Цэрэнжав, Хувьцаа эзэмшигч: ТУЗ-ийн даргаас асууя. Та өөр ямар Төрийн өмчит компанийн ТУЗ-д ажилладаг вэ? Д.Энхжаргал ТУЗ-ийн хараат бус гишүүнээс асууя. Та Тээвэр хөгжлийн банктай холбоотой хэвээрээ юу? Яагаад өөр банкны ТУЗ-д сууж байна вэ? ТУЗ-ийн гишүүн Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Б.Ганбат нь Монголын иргэний агаарын тээврийн ТУЗ-д суудаг. Эрдэнэс таван толгой ХК-ийн ТУЗ-д суудаг. Өөр хэд, хэдэн Төрийн компанийн ТУЗ-д суудаг. Миний мэдэхээр Төрийн банкны ТУЗ-д суугаад 14 жил болж байна. Бид өөр банкнуудтай өрсөлдөж байгаа. Төрийн банканд яагаад Оюу толгой ХХК-ийн данс байдаггүй юм бэ? Таван толгойтой яагаад ийм муу харьцдаг юм бэ? Монголын санхүүгийн том хөрөнгө эргэлдэж байдаг газруудтай Төрийн банк идэвхгүй ажиллаж байна гэж харагдаж байна. Гадагшаа гүйлгээ хийхэд Голомт банк, ХХБ-тай өрсөлдөж чадахгүй байна гэж иргэн хүний хувьд харж байна. Том бизнесменүүд бүгд өөр банкны карттай явдаг. Төрийн банк төвөгтэй гэдэг ойлголттой байдаг. Үүнийг хэзээ өөрчлөх юм бэ? Өрсөлдөх чадварын тухай яагаад дурдахгүй байгаа юм бэ?

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн хариулна уу.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Миний бие Эрдэнэс Монгол компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан. Хэрэг эрхлэх газар, Сангийн сайдын чиглэлээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн томилоход цаашид Эрдэнэс Монгол компанийн ТУЗ-д ажиллахгүй. Миний хувьд цаашид хувьцаа эзэмшигчид өөр шийдвэр гаргахгүй бол, зөвхөн Төрийн банкны ТУЗ-д үргэлжлүүлэн ажиллахаар байгаа.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: ТУЗ-ийн хараат бус Д.Энхжаргал гишүүн хариулна уу.

Д.Энхжаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүн: Миний эцэг Данзанбалжир, Тээвэр хөгжлийн банкныг байгуулаад бурхны оронд явсан. Миний бие Тээвэр хөгжлийн банканд амьдралдаа нэг ч удаа ажиллаж байгаагүй. Тээвэр хөгжлийн банкны хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн гишүүн байгаагүй. Монгол Улсын банканд нягтлан бодогчоос эхлээд Монголбанкны дэд ерөнхийлөгч хүртэл 30 гаруй жил тасралтгүй ажиллаж байгаад, Олон Улсын банк санхүүгийн байгууллагад зөвлөхөөр нэлээдгүй мэргэшсэн ажиллаж байгаа. Төрийн банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн буюу ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга хийдэг байгаа.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Цэрэнжав хувьцаа эзэмшигч маань Б.Ганбат, ТУЗ-ийн гишүүний талаар асуулт асуусан. Б.Ганбат гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар өнөөдөр Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирж амжаагүй байна. Цэрэнжав хувьцаа эзэмшигчийн асуусан асуулттай холбогдолтойгоор Гүйцэтгэх захирал Ө.Гантөр захирал хариулна уу.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Эх үүсвэр байхгүйгээр банк оршин тогтнохгүй. Тогтвортой эх үүсвэртэй байж, байж цаашид үйл ажиллагаа тогтвортой, өргөжих, тэлэх, ашигтай ажиллах нөхцөл бүрдэнэ. Ашигтай ажиллаж байж ногдол ашгаа өндрөөр тараана гэдэг зарчмыг барих бодлогыг хэрэгжүүлэн явж байгаа. Оюу толгойн хувьд бид хамтран ажиллах талаар анх үүсгэн байгуулагдсан цагаас нь хойш санал тавьсан. Тухайн компанийн өөрсдийн удирдлагуудын шийдэх асуудал байгаа. Эрдэнэс таван толгой ХК-тай хамтран нэлээн өргөн хүрээнд ажилладаг. Тус компаниас Төрийн банканд их хэмжээний томоохон дүнтэй эх үүсвэр байршуулан төлбөр тооцоо хийдэг. Орон нутгийн жижиг Таван толгой гэж байгаа. Тус компанитай үйл ажиллагаагаа өргөжүүлэн, тодорхой хэмжээний эх үүсвэрийг тодорхой хугацаанд байршуулаад явж байна. Орон нутгийн сумдад Хаан банк болон Төрийн банкны салбарууд л байдаг. Зах зээлийн эзлэлтийн хувиар 50, 50 хувьтай байдаг. Зах зээлийн эзлэлтийн хувийг нэмэгдүүлэх үүрэг даалгаврыг банкны удирдлагын зүгээс байнга шахаж үүрэг даалгавар өгч ажилладаг. Түүний үр дүнд 97.4 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаад явж байгаа болов уу, гэж бодож байна.

Мөнх-Эрдэнэ, Хувьцаа эзэмшигч: 1 дэх асуултыг манай харилцагчид надаар дамжуулан асуулгаж байгаа. 2 дахь асуултыг манай компани багахан хэмжээний хувьцаа авсан, иймээс цаашид хөрөнгө оруулалтаа нэмэх үү, яах уу, гэдэг шийдвэр гаргах шаардлагатай байгаа учраас асууж байна. Эхний асуултыг ТУЗ-ийн даргаас асууя. Ногдол ашгийн бодлогын шийдвэр ямар түвшинд биежиж гарах вэ? Тухайн тухайн жилдээ ТУЗ-өөр хэлэлцээд явах уу? Эсвэл журамд оруулаад явах юм уу? Компанийн дүрэмд оруулаад явах уу? Энэ бодлого хэр зэрэг дараа нь хялбархан өөрчлөгдөж чадах вэ? Эсвэл эс чадах вэ, гэдгээс хамаарч хөрөнгө оруулагчийн хувьд хэдийн хэмжээний ногдол ашиг авах нь тодорхой болох гээд байгаа юм. Банкнуудын хувьд хөрөнгө оруулагчаа татах гол тоглолт Ногдол ашгийн бодлого, түүнд суурилсан ногдол ашгийн өгөөж болж байна гэж харж байна. 2 дугаар асуултыг Гүйцэтгэх захирал Ө.Гантөр танаас асууя. Өнгөрсөн жил гүйцэтгэл маш сайн гарсан үүнд баяртай байгаа. Тийм ч учраас бид хөрөнгө оруулалтыг хийсэн. Эрсдэлийн сангийн зардал өнгөрсөн жил маш

бага гарсан байна. Үүнд баяртай байгаа боловч эхний улирлын аудитлагдаагүй тайлангаар нэлээн өсөөд гарч ирсэн байна. Урагшаа жилүүдийг аваад үзэхээр 2020 он 2021 онд өндөр эрсдэлийн сангийн зардал гарч байсан байна. 2022 онд маш бага, бараг байхгүй болоод, энэ жилээс нэмэгдэх гээд байгаа юм шиг харагдаж байна. Тэгэхээр энэ нэмэгдэх үү? Нэмэгдвэл ямар хэмжээгээр нэмэгдэх вэ? Гэдэг дээр тооцоолол өгнө үү, гэж хүсэж байна.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Б.Тэлмүүн дарга хариултыг өгнө үү.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Ногдол ашгийн хувьд 1 дүгээрт, миний бие Төрийн болон Төрийн өмчит компанийн анхдагч хуулийн төсөл дээр УИХ-ын ажлын хэсэгт ажиллаж байгаа. Үүн дээр ЗГ-ын болон бидний өргөн барьсан хууль, цаашид тогтвортой ногдол ашгийн бодлоготой байж гэж байгаа. Өмнө нь олон жил Төрийн өмчит компаниуд ашигтай ашиггүйн хороонд ихэнх нь явдаг байсныг өөрчлөөд явж байгаа. Энэ жилээс анхны шийдвэр цэвэр ашгийн 50 хувь гэж байгаа. Яг 50 хувь, 40 хувь, 60 хувь, байх уу гэдэг дээр дахин нягтлах хэрэгтэй байгаа. Бусад системийн хэмжээний банкнуудын бодлого, зах зээл дээрх өрсөлдөөнийг харж байж ТУЗ-өөс ногдол ашгийн талаар баримтлах бодлогоо шинэчлэн батална. Таны хэлж байгаа тогтвортой ногдол ашгийн бодлоготой энэ нь тухайн үеийн удирдлагуудаас хамаарч өгнө, өгөхгүй гэдэг тийм Олон улсын жишигт нийцсэн чиглэлийг баримтлан явна. Аль болох энэ жилийн жишгийг бууруулахгүй хадгалахыг хичээж явна. Мэдээж банк санхүүгийн салбар, макро эдийн засгийн салбартай холбоотой тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан үзэх зайлшгүй шаардлага байгаа.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Эрсдэлийн сантай холбоотой асуудал ярьж байна гэдэг нь цаана нь активын чанарыг ярьж байна гэсэн үг. Актив чанартай байх юм бол эрсдэлийн сан байгуулахгүй, эрсдэлийн сангийн зардал гарахгүй. Тэр утгаараа ашиг нэмэгдэнэ. 2022 онд Олон улсын валютын сангийн зөвлөснөөр Монголбанк болон Казакстан Улсын хөндлөнгийн аудитын байгууллага, системийн 5 том банканд активын чанарын үнэлгээ хийсэн. Энэ үнэлгээгээр Төрийн банк, сан нэмж байгуулах шаардлагагүй, ангиллаа зөв хийсэн байна гэдэг дүгнэлт гарсан. Бусад банкнууд дээр сан байгуулах асуудал яригдсан. Тэгэхээр Төрийн банкны хувьд ангиллаа тогтмол сар болгон зөв хийж байгаа. Сангаа бүрэн байгуулаад явж байгаа. 2023 оны эцсээр бид бүхэн 57.0 тэрбум төгрөгийн ашигтай ажиллана гэсэн тооцоололтой байгаа. Эдийн засгийн нөхцөл байдлыг харахад Ковидын нөхцөл, хил гааль хаалттай байдлаас шалтгаалаад бизнес эрхлэгчдийн нөхцөл байдал хязгаарлагдаж, хүндэрсэн. Үүнтэй уялдуулаад нөлөөлөл нь 2022 он болон 2023 онд гарах магадлалтай байгаа. 2023 онд хэрэглээний зээл дээр анхаарч ажиллах шаардлага үүсэж байна гэж харж байгаа. Тиймээс үүн дээрээ төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа.

Сүрэнхорлоо, Хувьцаа эзэмшигч: Юуны өмнө өнөөдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирж оролцож байгаа Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Төрийн банк анхдугаар хурлаараа хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг тараах асуудлыг танилцуулж байгаа нь миний хувьд таатай байна. Ногдол ашгаа хувьцаа эзэмшигчдэд эхний жил өгч байгаа нь цаашид Төрийн банк маань дахин хувьцаа гаргахад иргэдийн итгэл, сэтгэл улам нэмэгдэх болов уу, гэсэн бодолтой байна. Энэ ажлыг хийхэд Төрийн банкны нийт 400 гаруй ажилчдын бүтээмж, ажлын үр дүн сайн байгааг илтгэж байгаа учраас бүх ажилчдад цаашдын ажилд нь амжилт хүсэж, сайн сайхан бүхнийг хүсье. 2022 оны Санхүүгийн ерөнхий тайланг сонслоо. 98 хувийн биелэлттэй гэж гарсан байна. Ковид цар тахал гэх хүнд нөхцөл байдалд ажиллаж,

өмнөх жилүүдээс ашиг нэмэгдсэн байдлаас сайн, ажлын амжилтууд харагдаж байна. 2023 онд томоохон хийх ажлуудын зорилт юу байна вэ?

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Ө.Гантөр захирал хариултыг өгнө үү.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: За баярлалаа. Бид бүхэн 2021 оны 8 дугаар сард ЗГ-аас Дундаж давхаргыг дэмжигч банк болгон зарласан. Дунд хугацааны стратеги төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулаад хэрэгжүүлээд явж байгаа. Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл 92 хувьтай байна, гэж танилцуулсан. Байгаль орчин нийгмийн засаглалын бодлогын ТУЗ-өөр батлуулсан. 2023 онд тус бодлогын хүрээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагч хадгаламж эзэмшигч нартаа түлхүү санал болгохыг зорьж байгаа. Мөн картын төлбөр системийг сайжруулах үүднээс Мастер карттай хамтын ажиллагааг өргөжүүлэх тал дээр ажиллаад явж байна. Цахимжуулах ажлын хүрээнд хэрэглээний зээл дотор цалин болон тэтгэврийн зээлийг бүрэн цахимжуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Зээлийг нэгж дээр судалж, дүгнэлт гарган, цаашлаад хороодоор хэлэлцэн дүгнэлт гаргадаг. Зарим нэг хэрэглээний болон цалингийн зээлд үнэлгээ өгөхдөө скорингийн программаар хийдэг болгох зэрэг ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.

Нанжид, Хувьцаа эзэмшигч: Төрийн банктай олон жил хамтран ажиллаж, санхүүгийн тусламж авч ажил үүргээ гүйцэтгэж ирсэн. Үүндээ баяртай байна. Төрийн банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээ ямар байгаа вэ? Гадаадын санхүүгийн байгууллагаас авсан зээл, тусламж эх үүсвэрийн талаар тодорхой мэдээлэл өгнө үү.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Ө.Гантөр захирал хариултыг өгнө үү.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Бид бүхэн Олон улсын зэрэглэл тогтоодог МҮҮДИС компаниар жил болгон санхүү болон үйл ажиллагааны байдлыг шалгуулж зэрэглэл тогтоолгодог. Тухайн байгууллага 2022 онд В буюу тогтвортой зэрэглэлээр тогтоосон. Энэ жил мөн зэрэглэлээ тогтоолгохоор холбогдох мэдээллүүдээ өгөөд явж байгаа. Эх үүсвэрийн хувьд дотоодоос эх үүсвэр татахаас гадна гаднаас эх үүсвэр татах ажлыг эрчимтэй хийж байгаа. 3 жилийн өмнөөс Фронтклир компанитай хамтран ажиллаж байгаа. Энэ компаниас нийт 25.0 сая долларыг тогтвортой байршуулж, эргээд үр өгөөжтэй байршуулах замаар ашгаа хүртээд явж байгаа. Сүүлд Каргил гэх компанитай хамтын ажиллагааг эхлүүлээд явж байгаа. Тухайн байгууллагаас 25.0 сая долларын эх үүсвэрийг байршуулсан. Гадаадаас нийт 46.0 сая доллар буюу 170.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр татсан байна. Банк эх үүсвэргүйгээр оршин тогтнохгүй. Тиймээс аль болох тогтвортой бага хүүтэй эх үүсвэрийг гаднаас болон дотоодоос татахыг зорьж ажиллаж байна.

Баасанжав, Хувьцаа эзэмшигч: Банк санхүүгийн мэргэжлийн хүн биш, математикийн багш 30 хэдэн жил улсад ажилласан хүн байна. Миний зүгээс хувьцаа эзэмшигчийн хувьд энэ ТУЗ-ийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Дандаа Сангийн яам, Монголбанкныхан голдуу байна. Энэ улсууд хэдэн жил суух вэ? Ийм улсуудаар удирдуулмааргүй байна. Жижиг хувьцаа эзэмшигч нараас банк санхүүгийн мэргэжилтэй залуу хүмүүсийг оруулах дээр анхаарч үзмээр байна. Би Хөрөнгийн биржийн хувьцааг эзэмшдэг, өчигдөр хувьцаа эзэмшигчдийн хуралд суусан. С.Мөнгөнчимэг дэд сайд Та бас удирдсан. Та бодвол Төр төлөөлж байгаа болов уу гэж бодож байна. Ө.Гантөр захирлын танилцуулгаас 300 хувь дахин давуулан ажилласан гэж байна. Үүнд бид бүхний хувь өчүүхэн багаас том хүртлээ орсон шүү дээ. Тэгэхээр бидний санаа тусмаар байна. Миний бодлоор ТУЗ-ийн дарга энэ хурлыг удирдмаар юм шиг. Гэтэл Хөрөнгийн

биржийн хурлыг удирдаад, өнөөдөр Төрийн банкны хурлыг удирдаж байна. Энэ ямар учиртай вэ? Энд ямар санаа байна вэ? Би Сангийн яамыг үндсэндээ хардаж байна. Хүний эрхийн хуулиар хардах эрхтэй. ТУЗ-ийн гишүүдэд санхүү мэргэжлийн нарийн мэргэшсэн, гадаад, дотоодод сурсан хүмүүс байгаа юм байна тэрийг ойлголоо. ТУЗ-ийн гишүүд 2023 онд ингээд яваад дуусдаг юм байж, 2024 онд өөрчилж, улиг домог болсон, энд тэнд ТУЗ-ийн гишүүнээр суудаг хүмүүсийг байлгамааргүй байна. Дахин хувьцаа гаргана гэдэг нь болж байна. Гэтэл ХДК гэх байгууллага яагаад жижиг хувьцаа эзэмшигч биднээс илүү хувийг эдлээд байгаа юм бэ? Үүний учрыг тайлбарлаж өгнө үү. ТУЗ-ийн дарга хариулт өгөхийг хүсэж байна.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Сангийн сайдаас удирдамж өгсний дагуу өчигдөр Хөрөнгийн биржийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг, өнөөдөр Төрийн банкны хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалж хуралдуулахаар ТУЗ-ийнх нь шийдвэрийн гарсны дагуу хурлыг удирдаад явж байгаа юм. Таны хэлсэн саналуудыг бодлого, зарчмын хувьд дэмжиж байгаа. Ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр онцгой анхаарал хандуулан ажиллана. Өчигдөр Та хөрөнгийн биржийн хурал дээр суусан бол миний хэлсэн үгийг мэдэж байгаа байх, ТУЗ-ийн гишүүдийн 2 хүнийг нь жижиг хувьцаа эзэмшигчдээс оруулах боломжийг нь бүрдүүлж өгсөн байгаа. Төрийн банкны хувьд ч гэсэн жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр, өмнөх хурлаар Хяналтын зөвлөлтэй болгож өгсөн, ажиллах журамтай болгосон. Жижиг хувьцаа эзэмшигч Хяналтын зөвлөлд орж ажиллах боломжтой. Дээр нь ТУЗ-д орох боломжийг бид бүрдүүлж өгч байгаа, түрүүн хэлсэн ТУЗ-ийн нэг гишүүн чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн байгаа. Энэ хүний оронд Төрийн төлөөллийн хувьцаа эзэмшигчийн төлөөлөл биш жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах байдлаар нээлттэй сонгон шалгаруулалт хийж, үе шаттайгаар ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хурлаар хангаад явна гэсэн бодлогыг баримтлан явна. Цаашид бид аль болох нээлттэй, олон нийт Та бүхний оролцоог оруулж ирэх тал дээр анхаарч ажиллаж байгаа. Үүнийг албан ёсоор хэлмээр байна. За эхний асуудал цахимаар асуулт байхгүй байна. Заалнаас 6 хүн асуулт асууж, хариултыг өгч 1 дэх хэлэлцэх асуудал өндөрлөлөө. Эхний асуудалд цахимаар санал хураалтыг эхлүүлсэн ба Та бүхэн хурлаар хэлэлцэж байгаа эхний асуудалд санал өгөх боломж бүрдэж байна. 2 дахь хэлэлцэх асуудалдаа орё. “Төрийн банк” ХК-ийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай тогтоолын төслийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн таныг индэрт урьж байна.

2. *“Төрийн банк” ХК-ийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай тогтоолын төсөл*

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: “Төрийн банк” ХК-ийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай танилцуулгыг хийв.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой асуултыг заалнаас авъя.

Сүхбаатар, Хувьцаа эзэмшигч: Төвлөрлийг сааруулахаар хувьцаагаа нэмж гаргахыг сайшаалтай гэж үзэж байна. Өмнө гаргасан 590 төгрөгөөр хувьцаагаа гаргах уу? Хувьцааны үнэлгээ өөрчлөгдөх үү? 14 хувийг энэ онд багтаж гаргах юм уу? 2023 он 2024 он гэж гаргах юм уу? Төрийн банкны 500 гаруй салбаруудын ихэнх нь өөрийн байр байна уу? Түрээсийн байр байна уу?

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Ө.Гантөр захирал хариултыг өгнө үү.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Ерөнхийдөө цаашид 20 хувиар тогтохгүй нээлттэй болох ёстой гэж бодож байна. Үнэлгээний хувьд гаргаснаас хойш тогтвортой байсан. Хаан банкны хувьцаа гарахтай холбоотойгоор тодорхой хэмжээгээр доошоо буусан байгаа. Өнөөдрийн байдлаар хувьцааны үнэ 605 төгрөгтэй явж байна. Анх 590 төгрөгөөр санал болгож гаргасан. Нэмж гаргах хувьцааны үнийн хувьд шууд хэлэх боломж байхгүй. Үнэлгээний компани үнэлж, аудитын компани үнэлэлт дүгнэлт өгч, Андеррайтерийн компани зах зээлийн судалгааг хийж байж хэдий хэмжээний хувьцааг ямар үнээр гаргах нь тодорхой болно. Орон нутагт түрээсийн байр дийлэнх нь байгаа. Банкны зүгээс жил болгон 7-10 хүртэлх нэгжийг шинээр баръя, гэсэн бодлого барьж ажилладаг. Яваандаа өөрийн гэсэн байртай болно гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Энхбаяр, Хувьцаа эзэмшигч: Татан төвлөрүүлсэн хөрөнгийг юунд зарцуулах вэ? Зохистой харьцаа 25 хувьтай байгаа нь Монголбанкны шаардлагыг хангаж байгаа боловч, нөгөө талаас өөрийн хөрөнгийн ашиглалт доогуур байгааг харуулж байна. Нэмж хөрөнгө татахад тэр хөрөнгийн ашиглалт муудаж, хөрөнгийн өгөөж буурчих юм биш биз дээ, гэсэн болгоомжлол байна. Тэгэхээр үүнийг нэмж хувьцаа гаргах биш, Сангийн яам хувьцаагаа зарах байдлаар хийсэн бол одоогийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаа илүү үр ашигтай болох байсан биш үү? Өөрийн хөрөнгийг Монголбанкнаас 12 хувь байхыг зөвшөөрч байгаа. Тэгэхээр 25 хувьтай явж байна гэдэг нь одоо байгаа өөрийн хөрөнгөө гүйцэт ашиглахгүй байна гэсэн үг. Нэмж хөрөнгө татах санхүүгийн хувьд хэр оновчтой шийдэл вэ?

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Хувьцаа эзэмшигч Сүхбаатар 20 хүртэлх хувийг нэг удаа бөөнд нь гаргах уу? Үе шаттай гаргах уу? гэж асуусан. Үүнд банкнаас хариулаагүй. Үүнийг тодотгож хариулж өгнө үү. Банк зах зээлийн нөхцөл байдал, эрсдэлээ тооцож, юу гэж харж байна вэ? Хэрхэн яаж гаргах нь одоо хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн хувьцааны үнэлгээнд тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлэх учраас энэ талаар хариултыг өгнө үү.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төрийн банкны хувьд системийн хэмжээний 5 банкнаас хамгийн анх хувьцааг гаргасан. Тухайн үед эдийн засгийн нөхцөл байдал тодорхойгүй, Ковидын дараагийн жилүүд байсан учраас бид 5 хувийг санал болгож гаргаж 25.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Хаан банк, ХХБ, Голомт банк, Хас банк хувьцаагаа гаргах ёстой. Өнөөдрийн байдлаар Голомт банк, Хаан банк гаргасан байгаа. ХХБ, Хас банк үлдэж байгаа. Энэ 2 банк нийтдээ 100.0 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлэх болов уу, гэсэн урьдчилсан таамаглал байна. Монголын хөрөнгийн зах зээлийн багтаамж хэр билээ гэдгийг бид бүхэн тооцоолж үзэх шаардлагатай байгаа. Тиймээс 14.29 хувь буюу нийт 134.0 сая ширхэг хувьцаа гаргах юм бол 1 дүгээрт, зах зээлийн багтаамж эрэлт муу байгаа. 2 дугаарт, их хэмжээгээр гаргах юм бол одоогийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны үнэлгээнд сөргөөр нөлөөлөхөөр байгаа. Тэгэхээр хувьцааг үе шаттайгаар гаргах боломжийг тооцож судлах ёстой гэж бодож байгаа. Үүн дээр Хөрөнгө зохицуулалтын газрын захирал Д.Жадамбаа дэлгэрэнгүй тайлбар өгч болно.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Олон нийтэд нээлттэй болгох шийдвэр УИХ-аас гардаг. 2022 онд гарсан УИХ-ын 16 дугаар тогтоолоор нэмж хувьцаа гаргах замаар гэж тодорхой заасан байгаа учраас бид нар энэ тогтоолын хүрээнд нэмж хувьцаа гаргах, олон нийтэд нээлттэй болгох үйл ажиллагаа явна.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төлбөрт түргэн гүйцэтгэх чадвар 25 хувь, өөрийн хөрөнгө 12 хувьтай гэж асуусан үүнд хариулт өгье. Энэ нь Монголбанкнаас тавьдаг шаардлага байгаа. Бид үүнийг сар болгон бүрэн хангаад явж байгаа. Одоо нэмж гаргах хувьцааны боссон хөрөнгийг юунд зарцуулах гэдгийг бизнес төлөвлөгөөндөө тусгасан байгаа. Дундаж давхаргыг дэмжих, байгаль орчин нийгэм засаглал, цахим шилжилт, ногоон санхүүжилт тал руугаа зарцуулна гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Энэ нарийвчилсан төлөвлөгөө Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанканд хүргэгддэг танилцуулга дээр илүү тодорхой тусгагдах юм.

Хувьцаа эзэмшигч: Мэргэшсэн боловсон хүчний нөөц бүрдүүлэлт, цаашид ажиллах боловсон хүчний тогтвортой ажиллах, хөгжүүлэх тал дээр ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төрийн банкны 4000 ажилтан банкны бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх тал дээр хичээн зүтгэж ажиллаж байгаа. Хүний нөөцийн зах зээлийн өрсөлдөөнийг анхааралтай судалж, ажиглаж өөрсдийн дотоод журам зааварт тусган ажилладаг. Тэр утгаараа гүйлгээний ажилтан болон эдийн засагч буюу харилцааны менежерүүдэд 3 зэрэглэл тогтоож, холбогдох цалин урамшуулалтай уяж явж байгаа. Мөн ажилласан жилийн байдлыг харгалзаж тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа. Орон нутагт ялангуяа хүний нөөцийн дутагдал нэлээдгүй байдаг. Үүн дээр анхаарал хандуулан ажилладаг. Тэр ч утгаараа Санхүү эдийн засгийн их сургуультай хамтран ажиллаж, цалинтай оюутан гэх хөтөлбөрийг хэрэгжүүлээд явж байгаа. Өөрөөр хэлбэр төгсөх курсийн оюутнуудыг тодорхой хугацаанд авч ажиллуулж, төгссөний дараа Төрийн банканд ажиллах боломжийг бүрдүүлж өгч байгаа юм.

Д.Жадамбаа, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал: Үлдсэн 14.29 хувийг гаргах хуулийн шаардлага байгаа. Зах зээлийн нөхцөл байдлын хувьд тодорхой хэмжээний зах зээл байгаа гэж харж байгаа. Гэхдээ нэг дор их хэмжээгээр буюу өнгөрсөн жилээс ойролцоогоор 3 дахин их гаргах нь одоогийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны үнэ цэнийг бууруулах, хөрөнгийг бууруулах үзэгдэл ажиглагдаж магадгүй гэсэн хүлээлт байгаа. Тиймээс тодорхой хэмжээгээр, учраас үе шаттайгаар зах зээлийн нөхцөл байдалтайгаа уялдуулж, хуваарилан гаргах нь зүйтэй болов уу, гэсэн судалгааны үр дүн гарч байгаа.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Цахимаар асуулт санал байна уу? Төрийн өмчит компаниудыг олон нийтэд нээлттэй болгох бодлогыг УИХ, ЗГ-аас авч хэрэгжүүлээд түрүүчээсээ ажилттай явж байгаа. Үүний нэг жишээ, өнөөдөр хувьцаа эзэмшигчдийнхээ хурлыг хийж байгаа Төрийн банк маань бусад банкнуудаа манлайлаад явж байгаа. УИХ-ын тогтоол дээр 20 хүртэлх хувийг гаргана гэж явж байгаа. Цаашлаад 20 хувиас дээш хувийг олон нийтэд нээлттэй болгох нь зах зээлийн үндсэн зарчим, хүн болгон банкны хувьцаа эзэмшигч болох боломжийг бүрдүүлж, үр өгөөжийг хүртэх энэ тал руу үе шаттайгаар явах нь зүйтэй. Заалнаас асуусан хүний асуулт дээр би тодотгож асууж байгаа нь, нэмж гаргах 14.29 хувийг нэг дор гаргах юм уу, үе шаттайгаар гаргах юм уу, гэдэг дээр ерөнхийдөө үе шаттайгаар гаргана гэдэг тооцооллыг гаргаж байгаа юм байна. Үүнийгээ энэ хурлаас гарах тогтоолын төсөл дээрээ тодорхой, ойлгомжтойгоор найруулж гаргаарай гэж хэлье. Яагаад гэвэл бөөнд нь гаргавал одоо байгаа хувьцаа эзэмшигчдийн хувьцааны үнэлгээнд сөргөөр нөлөөлөх, үе шаттайгаар гаргавал нөлөөлөл бага, эерэг өгөөжтэй байх гэх мэтчилэн зах зээлийн нөхцөл байдал ямар байх, хэрхэн яаж тооцож байгаа тал дээр анхаарч хурал даргалагчийн зүгээс хурлаас гарах тогтоол дээр тодорхойлж найруулгын саналыг оруулах нь зүйтэй гэсэн саналыг хэлье. За ингээд 2 дахь асуудлаа дуусгая. Дараагийн хэлэлцэх 3 дахь асуудалдаа орёе.

“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн таныг индэрт урьж байна.

3. *“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл*

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Төрийн банк ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн танилцуулгыг хийв.

Ганбаяр, Хувьцаа эзэмшигч: Хяналтын зөвлөлд дэвшсэн 8 хүний нэг нь би байгаа юм. Надад өгсөн мэдээлэл болон сая энд яригдсан 2 мэдээлэл зөрөөд байна уу, эсвэл би буруу ойлгочхов уу. Надтай ярихдаа миний өгсөн материалын дагуу үзэж байна гээд, и-мэйл хаягаар надаас тодруулга авсан. Та банк, санхүүгийн байгууллагад үндсэн ажилтнаар ажиллаж байсан эсэхээ тодруулаарай гэж байгаа юм. Би ажиллаж байгаагүй ээ гэдгээ хэлсэн. Тэгээд надад ирсэн хариу нь болохоор, Та банк санхүүгийн салбарт ажиллаж байгаагүй юм учраас таныг дэвшүүлсэнгүй, таны материал дэмжигдсэнгүй гэсэн хариу өгсөн. Тэгэхээр энэ чинь түрүүн ярьсантай зөрчхөв үү, би буруу сонсчхов уу. Тэгээд үүн дээр тодруулга авмаар байна. За тэгээд бас нэг зүйл байна. 2023 оны 1 дүгээр улиралд тайлан чинь бусад хувьцаагаа гаргасан системийн 2 банк болон Богд банкттайгаа харьцуулахад хасахтай гарчхаж байгаа юм биш үү. Би буруу хараад байна уу? Бусад банкнууд чинь нэмэхтэй гарсан байхад, Төрийн банкны маань ашигт ажиллагаа буурсан байна. Үүн дээр аудит хийсэн хүмүүс нь хариулбал зүгээр байна. Баярлалаа.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: 1 дүгээр асуултад, Д.Энхжаргал хараат бус гишүүн хариулна. 2 дахь асуултад Ө.Гантөр захирал хариулна.

Д.Энхжаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүн: 1 дүгээр асуултад хариулъя. Төрийн банкны Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 3 дугаар тогтоолоор баталсан. Тавигдах шаардлагын тухай би түрүүн тодорхой хэлсэн. Банк санхүү, эрх зүй, эдийн засаг, бизнесийн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан мэдлэг туршлагатай. Банк санхүүгийн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг банк болон бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан ажилтан, эсхүл түүний холбогдох этгээд бус байх, бусад банкны хувьцаа эзэмшигч бус байх, Төрийн банкны хувьцаа эзэмшигч иргэн байх гэдэг нотлох баримтуудыг өгөх ёстой байсан. Ийм шаардлагууд тавьсан байгаа. Хувь хүний нууцын хуультай холбогдуулаад тухайн иргэнтэй холбогдолтой асуудлуудаар бид нар хариу захиаг илгээсэн байгаа. Энэ хурал дээр дэлгэрэнгүй ярих шаардлагагүй гэж үзэж байна. Та энэ материалыг манай ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас үзэх боломжтой. Таны хаягаар яагаад шаардлага хангахгүй байгаа талаар захидлыг илгээсэн болно оо, хэрвээ танд очоогүй бол ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас, ажлын албанаас авч үзэх боломжтой шүү.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Ашгийн хувьд асууж байх шиг байна. Санхүүгийн тайлан жилийн эцсийн байдлаар аудитлагдаад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлагначихсан байгаа. Улирал болгон бид бүхэн холбогдох санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонинд хэвлэж гаргадаг байгаа. 1 дүгээр улирлын байдлаар бид 24.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байгаа, хасах биш.

Энхбаяр, Хувьцаа эзэмшигч: Хяналтын зөвлөлийн журам дээр санал байна. Энэ дээр хяналтын зөвлөлийн гишүүний цалинг тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс илүүгүй хэмжээтэй байна, гэсэн байна. Тэгэхээр энэ чинь 1 сая төгрөг л болчихоод байна л даа. Тэгэхээр одоо өнөөдөр, өндөр мэргэжлийн хүн ямар цалинтайгаар ажиллаж байгаа билээ? Тэгэхээр сая төгрөгөөр хүнийг ажилла гэхээр, хүмүүс бас орохыг хүсэхгүй байх нь ойлгомжтой юм биш үү. Өнөөдөр өндөр мэргэжлийн хүний нэг цагийн ажлын хөлс 400,500 мянгаас 1 сая төгрөг хүртэл байгаа шүү дээ. Тэгээд энэ цалин дээрээ жоохон нарийлчихсан юм шиг, хангалттай өндөр тогтоовол яасан юм бэ? Ажилласан цагаас нь боддог ч юм уу, үүнийг заавал энэ журам дээр тогтоохгүй, ТУЗ-ийн эрх мэдэлд өгчихвөл яасан юм бэ, энэ цалингийн асуудлыг, ийм бодол байна.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Ерөнхийдөө Хяналтын зөвлөлийн гишүүдийн цалин урамшуулалтай холбоотой санал хэлж байх шиг байна. За одоогийн яг журамдаа оруулснаар бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр 550 мянга байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, энийг 2 дахин нэмэгдүүлэхээр 1 сая 100 мянга дотор, хяналтын зөвлөлийн гишүүний цалин байна, гэсэн жишиг оруулж ирсэн. Энэ жишиг нь Төрийн өмчит компанийн тухай хуулиар ТУЗ-ийн гишүүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний цалин авна гэсэн ийм жишиг байдаг учраас энэ жишгээр оруулж ирсэн юм байна. Тэгэхлээр Хяналтын зөвлөл маань өөрөө байнгын биш шинж чанартай учраас цалин урамшуулал нь ерөнхий жишгийнхээ дагуу явах нь зүйтэй юм болов уу гэж бодож байна. Хяналтын зөвлөлийн 7 гишүүнд маань жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл орох эрх нь бүрэн нээлттэй байгаа. Та бүхэн өөрсдийнхөө материалыг өгөөд Хяналтын зөвлөлийн гишүүн болоод, Хяналтын зөвлөлийн ажиллах чиг үүргийн дагуу компанийн үйл ажиллагаанд оролцох, ил тод байх, засаглалыг сайжруулах, энэ үйл ажиллагаанд нь оролцож эрхээ эдлээч ээ гэж Та бүхнээс хүсмээр байна.

Оч, Хувьцаа эзэмшигч: Хяналтын зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулалт чинь хэтэрхий хүнд нөхцөл тавиад байгаа юм биш биз дээ, энэ чинь ерөөсөө 1 ч хүн саналаа өгөөгүй байж болохгүй, 8 хүнээс нэг нь л саналаа өгсөн байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас анхаарч үзээрэй гэж хүсэж байна. Энэ сая их хурлаар Хөгжлийн банкны асуудлуудыг ярьж байхад, зээл олголтын хариуцлагагүй байдал Улс орны эдийн засагт ихээхэн хэмжээгээр муугаар нөлөөлсөн гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр манай Төрийн банкны зээлийн эдийн засагч нарын чадавх ямар байна вэ? Зээл олголтын үйл ажиллагаанд байгууллагын дотоод хяналтыг яаж хийдэг вэ? Яригддаг асуудал нь 10 хувь олгохгүй бол зээл өгдөггүй гэсэн, өгсөн байгаа нь шаардлага хангаагүй хүмүүст зээл олгодог. Төрийн банк энэ тал дээр онцгой анхаарч ажиллаасай гэж хүсэж байна.

Мөнгөнчимэг, Хурлын дарга: За эхний асуултад Д.Энхжаргал ТУЗ-ийн гишүүн хариулна. Өнөөдөр тус журамд өөрчлөлт оруулах асуудал бас орж байгаа учраас, үүн дээр манай хувьцаа эзэмшигч нар саналаа өгөх бололцоотой шүү.

Д.Энхжаргал ТУЗ-ийн Хараат бус гишүүн: Хувьцаа эзэмшигчийн саналыг бол зөвшөөрч байгаа. Нэр дэвшүүлэх хороо нэгэнт хувьцаа эзэмшигчид өөрсдийнх нь баталсан энэ журмын дагуу ажиллаж байгаа, журамд энэ шаардлагууд байгаа учраас Нэр дэвшүүлэх хороо журмын шаардлагыг баримтлахаас өөр аргагүй нөхцөлд ажилласан. Өнөөдөр хувьцаа эзэмшигчид өөрсдийнхөө бүрэн эрхийн хэмжээнд энэхүү журамдаа өөрчлөлт оруулах бас боломж байгаа.

Шаардлага өндөр байгаа гэдэгт би хувь хүнийхээ хувьд болон хараат бус гишүүнийхээ хувьд ижил тантай ижил байр суурьтай байна. Баярлалаа.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Эдийн засагч нарын чадавх ямар байна вэ, гэж байна. Бид хүний нөөцийнхөө бодлогын хүрээнд, банк санхүүгийн мэргэжлээр төгссөн болж өгвөл, нэр хүндтэй Монгол Улсын Их Сургууль, Санхүү эдийн засгийн дээд сургуулиудыг төгссөн оюутнуудаас шилж сонгож ажиллуулахыг эрмэлздэг. Шилж сонгоод, дотооддоо мөн харилцааны менежер буюу эдийн засагчийн сургалтыг зохион байгуулаад дадлагажих ажилтнаар 3 хүртэл сараар ажиллуулдаг. Хяналтын тогтолцооны хувьд нэгж дээрээ тухайн зээл хүсэгч маань хүсэлтээ өгөөд, нэгж дээрээ судлагдаад тооцооны төв дээр гэсэн үг. Тэгээд салбарын холбогдох хороогоор ороод, зээлийн хэмжээнээс шалтгаалаад зээлийн дэд хороо эсвэл зээлийн ерөнхий хороогоор орж шийдэгдэж байгаа. Хороогоор орохоос өмнө хууль болон эрсдэлийн дүгнэлт гардаг. Эрсдэлийн дүгнэлтийг 80 сая төгрөгөөс дээших дүнтэй зээлүүд дээр гаргаж байгаа. За банкны нийт зээлийн багцыг аваад үзвэл 13 хувь нь бизнесийн зээл үлдэж байгаа 87 хувь нь хэрэглээний буюу цалин, орон сууц, малчны болон бусад жижиг зээлүүд эзэлж байгаа юм. Мөн дээрээс нь одоо манай банкны хувьд дээд тал нь 5.0 тэрбум төгрөгийн зээлийг олгож байгаа, 5.0 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй зээл олгохгүй байгаа. Мөн Гүйцэтгэх захирлын харьяанд Дотоод хяналт шалгалтын газар ажиллаж байгаа. Дотоод хяналт шалгалтын газар нь Улаанбаатар, Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нэгжүүдээр төлөвлөгөө гаргаад сар, улирал болгон шалгаад ажиллаж байгаа. Мөн ТУЗ-ийн дэргэд Дотоод аудитын газар гэж байгаа хяналт хэрэгжүүлэх 2 нэгж байгаа гэсэн үг. Дотоод аудитын газар маань хяналтын чиг үүргийнхээ дагуу хяналт шалгалт хийгээд явж байгаа. Баярлалаа.

Отгонбаяр, Хувьцаа эзэмшигч: Хяналтын зөвлөлд банк санхүүгийн байгууллагад заавал 5 жил ажилласан хүнийг оруулна гэдэг чинь аягүй чанга юм байна лээ. Би бас хүсэлтээ өгч үзсэн. Тэр шалгуурыг хангах нь бол хэцүү. Би бол хориод жил бизнесийн салбарт ажилласан юм. Тэгтэл тэр шалгуур дээр бол ер нь бол тэнцэхгүй байна лээ. 2023 оны 1 дүгээр улирлын тайланд 24.5 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байна лээ шүү дээ. Тэр чинь 22 оноосоо 1.7 хувиар унасан юм байна лээ. 2022 онд 10 их наядын хөтөлбөр хэрэгжсэн, долларын ханшны хэлбэлзэл явсан. Ер нь бол ашигтай ажиллах боломж байсан. 2023 оны 1 дүгээр улиралд энэ дээр тайлбараа өгөөчээ. Юун дээр зардал гараад байгаа юм, тэр гарч байгаа зардлууд чинь нэг удаагийн зардал юм уу, ер нь хойшид гарах зардлууд юм уу? Эндээс чинь шалтгаалж шийдвэрээ гаргана шүү дээ. Ингээд урьд оныхоо балансыг барьж явж чадахгүй бол, энэ чинь муу ажиллаж байгаа л хэлбэр байна шүү дээ. Тэгээд энэ дээр нэг тайлбар хүсье.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: За баярлалаа, одоо хэрэгжиж байгаа Хяналтын зөвлөлийн ажиллах журмаар тавигдсан шаардлагуудын хувьд 7 шаардлага байгаа. 1 дүгээрт нь бидний зүгээс өндөр, хатуу байна гэж харахгүй байгаа. 1 дүгээрт нь банкны энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх, 2 дугаарт банктай сүүлийн 2 жилийн хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд ороогүй байх гэсэн байгаа. Банкны ажилчид нь ороод байвал, олон нийт гэдэг талаасаа зохимжгүй болох байх. 3 дугаарт нь Банк санхүүгийн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг банк болон бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан, түүнтэй холбоотой этгээд бус байх, бусад банкны удирдлага, хамаатан садан орж болохгүй гэсэн санаа. 4 дэх нь бусад банкны хувьцаа эзэмшигч бус байх гэж байгаа, үүн дээр тухайн үед банкууд IPO хийгээгүй байсан учраас, өөр банкны том эздүүд ороод ирвэл зохимжгүй. 5 дахь нь банк санхүү, эрх зүй, эдийн засаг, бизнесийн чиглэлээр дээд боловсролтой мэргэжлээрээ 5-аас

доошгүй жил ажилласан мэдлэг туршилттай байх. Энэ зөвхөн банканд 5 жил гэсэн үг биш л дээ, бизнесийн чиглэлээр 5 жил, эдийн засгийн чиглэлээр 5 жил, өөрийнхөө мэргэжлээр 5 жил гэж байгаа юм. 6 дахь нь хугацаа хэтэрсэн аливаа хөтөлбөргүй байх гээд, энэ бол мэдээж байх нь зүйтэй байх. Гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь нотлогдож байгаагүй байх гэсэн, ийм шалгуурууд байгаа. Нэг талдаа бидний хувьд хяналтын зөвлөл гээд мэргэжлийн хяналт тавина гэсэн утгаараа тодорхой мэргэжлийг төлөөлөөд үйл ажиллагаа эрхлэх, ийм хүмүүс байвал зүгээр болов уу гэж оруулсан. Хяналтын зөвлөлд ТУЗ-д танилцуулагдсан мэдээллээр бол яг энэ 7 материалынхаа шаардлага хангасан эсэх материалыг бүрэн хангаж ирүүлсэн нэг ч материал байхгүй гэж ойлгосон. Жишээ нь, бусад банкны хувьцаа эзэмшигч бус байх, тухайн банкны ажилтан биш гэдгээ нотлох баримт ирүүлээгүй. Зүгээр огт материал ирээгүй орхичоод байсан гэсэн.

Мөнгөнчимэг, Хурлын дарга: Бидний хэлэлцэж байгаа асуудал маань журамтай холбоотой учраас, яг журмын тэдийн тэд дэх заалт дээр, тийм санал оруулъя гэдгээ тодорхой хэлээд санал оруулаарай. Үүн дээр олонхын шийдвэр гаргах зарчмаараа шийдээд явах боломж байгаа шүү. Ө.Гантөр захирал 2 дахь асуултад хариулна.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Ашигт ажиллагаатай холбоотой асуулт асууж байна. 2021 онд бид 45.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. 2022 онд 97.4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. 1 дүгээр улирлын асуудлыг ярьж байх шиг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бид нар 400 сая төгрөгөөр доогуур. За энэ маань юунаас нөлөөлсөн бэ, гэхээр бодлогын хүү 6-13 хувь хүртэл бол өссөн байгаа. Үүнтэй холбоотой харилцах, хадгаламжийн хүү өссөн. 2 дугаарт Ковидын тухай хуулийн дагуу хугацаагүй хадгаламж, валютын хадгаламжид хүү төлөхөөргүй заалттай байсан нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дуусгавар болоод, 1-р сарын 1-ээс бид хүү төлж эхэлсэн байгаа. Хугацаагүй хадгаламж дээр, валютын хадгаламж дээр за тэгээд дээрээс нь бодлогын хүү өссөн учраас харилцах, хадгаламжаа барьж тогтоох, эх үүсвэр татахын тулд бид хүүгээ зайлшгүй өсгөж таарна. Тэгэхээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад ойролцоо ажилласан гэдэг маань бол хүү төлөөд байхад бид харин ч илүү сайн ажилласан юм уу, гэж надад харагдахаар байгаа юм.

Мөнгөнчимэг, Хурлын дарга: Цахимаар ирсэн асуулт байна уу?

Отгонбаяр, Хувьцаа эзэмшигч: Зардлын талаар асуусан шүү дээ. Ямар зардлууд байгаа юм цаашдаа нэмэгдэх юм уу, хасагддаг юм уу нотлох баримт чинь?

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Зардалтай холбоотой асуудал дээр депозитын зардлууд байгаа.

Отгонбаяр, Хувьцаа эзэмшигч: Нөгөө талдаа 10 их наяд төгрөг ЗГ-аас оруулчихсан байгаа шүү дээ, эдийн засаг дээр. Тэгэхээр энэ чинь бас ийм ч их өндөр нөлөөлөл үзүүлэхгүй байхгүй юу. Би хувьцаа эзэмшигч талаасаа шахаж ярьж байна л даа.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: 10 их наяд төгрөгийн хөтөлбөр хэрэгжсэн ЗГ-аас хэрэгжүүлсэн. Бид маш амжилттай оролцсон. Нийтдээ 8700 гаруй иргэн ААН-д 44.0 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Бодлогын хүү өссөнтэй холбоотой хамгийн гол нь харилцах, хадгаламж дээр хүү төлж байгаа. Зардлын дийлэх нь харилцах, хадгаламж дээр төлж байгаа, хүү юм.

Мөнгөнчимэг, Хурлын дарга: Та бүхнээс өөр, асуулт санал байна уу? Санал байхгүй бол 3 дахь асуудлаа өндөрлөө. 3 дахь асуудалд, хяналтын зөвлөлийн ажиллах журамд яг тодорхой

тэдийн тэдийг ингэж өөрчилье гэсэн санал гаргасангүй. Ерөнхий байдлаар саналаа хэлээд явсан учраас, ерөнхийдөө орж ирсэн төсөл дээр, дэмжиж байна, дэмжихгүй гэдгээрээ саналаа өгөөд явахаар байна. За ингээд 3 дахь асуудлаа хэлэлцэж дууслаа. Одоо 4 хөтөлбөрийнхөө дагуу, 4 дэх асуудал руугаа орё. Төрийн банк ХК-ийн ХЭХ-ын журам батлах тухай тогтоолын төслийг хэлэлцэнэ. Танилцуулгыг Б.Тэлмүүн дарга танилцуулна. Журам хэлэлцэх гэж байгаа учраас, Та бүхэн маань журамд тодорхой саналуудаа хэлээрэй, материал тараагдсан байгаа.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батлах тухай танилцуулгыг хийв.

Мөнгөнчимэг, Хурлын дарга: Асуулт, хариултын хэсэгтээ орё. Хурлын материалын 42 дугаар хуудсан дахь журмын төсөлтэй танилцаад, асуулт, тодорхой санал гаргаж болно.

Энхбаяр, Хувьцаа эзэмшигч: Энэхүү журмын 6 дугаар бүлгийн 6.1 дэх заалтад саналын эрхтэй энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч санхүүгийн жил дууссанаас 60 хоногийн дотор асуудлаа тавьж болно гэсэн байна. Компанийн тухай хуульд ингэж заасан байдаг юм аа, гээд Тэлмүүн дарга сая хэллээ л дээ. Тэгэхдээ компанийн өөрийнхөө дүрэм журамд бас компанийн тухай хуулиас арай өөрөөр тусгаж болох тал бас байдаг шүү дээ. Компани дотроо шийдэх асуудал байгаа юм. Тэгээд 2 дугаарт ер нь 5 хувиас дээш гэвэл угаасаа жижиг хувьцаа эзэмшигч, одоогийн байдлаар боломжгүй байгаа. Тэгэхээр энэ хэлэлцэх асуудалд жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс, өөрөөр хэлбэл төрөөс бусад хувьцаа эзэмшигчид санал оруулах ямар ч боломжгүй болоод байна, энэ журмаараа. 2 дугаарт бид дараагийнхаа хувьцааг гаргах гэж байгаа энэ үед, хувьцаагаа аль болох дараагийн худалдан авагчдад сонирхолтой хэлбэрээр, тэдний эрх ашгийг хангасан хэлбэрээр байх юм бол, тэр хэмжээгээр хувьцааны ханш өсөх гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр мөн хугацааны асуудал байна. Санхүүгийн жил дуусахаас 60 хоногийн өмнө бид саналаа өгөх ёстой гэж байгаа. Гэтэл одоо Төрийн банк 15 хувиа зарлаа. Ажлууд нь явсаар байгаад 11 сарын сүүлээр ч юм уу шийдэгдлээ гэж бодъё. Гэтэл тэр үед хувьцааг худалдаж авсан хувьцаа эзэмшигч маань, 5-аас дээш хувь авлаа гэж бодъё. Тэр тохиолдолд дараагийн 4 сард, 2024 онд болох ХЭХ-д ямар ч эрх эдлэхгүйгээр оролцох гээд байгаа байхгүй юу. Тэгээд тэр хүн маань дахиад жил 6 сар, өөрийнхөө хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлээд ТУЗ-д төлөөллөө оруулах гэж дахиад жил 6 сар хүлээх ёстой болж байна шүү дээ. Тэгэхээр ахиад жил 6 сар хүлээхээр хувьцааны үнэ цэнэ худалдан авагчийн нүднээс харвал буураад явчихдаг юм шүү дээ. Энэ асуудал чинь бас нэлээн ноцтой асуудал юм биш үү? Яагаад вэ гэхээр хувьцаа эзэмшигч чинь хамгийн гол өөрийнхөө эрхийг ТУЗ-ийн гишүүнээр дамжуулж хэрэгжүүлж байгаа, дэлхийн жишиг ийм байгаа. Гэтэл энэ хүн, санал оруулах гэж бүхэл бүтэн жил 6 сар ямар ч эрхгүй болчих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр томоохон хувьцаа эзэмшигчид байвал ТУЗ-д төлөөллөө оруулах сонирхол байгаа. Тэгтэл энэ журмын 6.1 дэх хэсгээр энэ тохиолдлыг чинь хаачаад байна аа.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Энэ засаглалтай холбоотой асуудал нэлээн яригдсан. Хуулиудыг судалж үзээд, өнөөгийн жишгийг харж үзсэн. Хуулийн заалтаа бариад явчихдаг юм байна лээ. Хуулиас давсан журмууд бол зарчмын хувьд өөрчлөгдөөд байгаа юм. Яагаад өнөөдөр бид 5 хувиасаа нэмж 20 хувь хүргэе гээд байгаа шалтгаан нь энэ л дээ. Аль болох оролцоог хангаж байж тодорхой хэмжээний төлөөлөл үүсдэг. Магадгүй үнэт цаасны компаниуд төлөөлөл хэрэгжүүлэх эрх хэрэгжүүлээгүй байгаа. Саналын эрхийг нь цуглуулаад авдаг ч юм уу. Тэгэхээр хуулийн заалтыг бид нар зөрчөөд журмаа баталж бол болохгүй болчихоод, гарц ямар

байж болох вэ гэхээр, Хяналтын зөвлөлөөр дамжиж өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой саналууд, дээрээс нь хараат бус гишүүдээс ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой асуудал дээр гол дуу хоолой оруулах хэрэгтэй юм. Тэгэхээр ТУЗ гэдэг маань бие даасан байгууллага биш, хувьцаа эзэмшигчдийг төлөөлж байгаа байгууллага. Үүн дээр ТУЗ-ийн гишүүд заавал төрийн төлөөлөл гэхгүй. Бидний хувьд ч гэсэн, манай хараат бус гишүүдийн хувьд ч гэсэн. Бидэнд бас өдөр тутмын гомдол санал зөндөө ирдэг. Компанийн тухай хуулийн 66.1 дэх хэсгийг яагаад ингэж хатуу заасан байна гэхээр, байнгын ээлжит бус хурал зарлахтай холбоотой маргаан үргэлжлэх ийм эрсдэлтэй байдаг учраас ер нь хуулиар яг засаглалынхаа кодексоороо ингэж заасан байдаг юм. Тэгэхгүй бол байнгын ээлжит бус хурлын хэрүүл маргаан, үүнтэй холбоотой шүүхийн маргаан гэж байгаа. Нөгөө үндсэн үйл ажиллагаагаа явуулах бололцоогүй болгодог. Энэ зөвхөн манай хууль дээр ч биш, олон улсын ийм жишиг хандлагууд байдаг. Та бүхэн заавал хурал хүлээхгүйгээр, ТУЗ-ийн дарга, Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, ТУЗ-ийн ажлын алба, Хяналтын зөвлөлөөрөө дамжуулаад санал хүсэлтээ өгөхөд нээлттэй шүү. Бид үүн дээр ямар нэгэн байдлаар цааргалах, санал хүсэлт хүлээн авахгүй байх шаардлага байхгүй. Бид үүн дээр өнөөдөр нээлттэй ажиллах бүрэн боломжтой.

Энхбаяр, Хувьцаа эзэмшигч: Компанийн тухай хуульд заасан ч гэсэн, компанийн дүрмээрээ өөрсдөө өөрчилж болох шийдвэрүүд байгаа. Зарим заалтыг бол компани дээр өөрчилж болохгүй. Заримыг нь дотооддоо өөрчлөх боломж бол байгаа шүү дээ. 2 дугаарт, Тэр хугацааны асуудлыг бас хууль дээр нь заасан байдаг юм уу үгүй юм уу тэ. Тэгээд ээлжит бус хурлын тухай яриагүй шүү дээ. Ээлжит хурлын хэлэлцэх асуудал энэ тухай яриад байгаа. Ээлжит хурлын хэлэлцэх асуудалд саналаа оруулах боломжийн тухай яриад байгаа шүү дээ. Тэгээд ээлжит бус хуралтай бол хамаагүй асуудал яригдлаа л даа. Тэгэхээр жоохон бид ярьж байгаа сэдвээс арай өөр л юм ярьчих шиг санагдлаа.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Таны саналыг ойлгож байна. Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн үйлчлэх хүрээнд ярьж байгаа юм. Хяналтын зөвлөл дээрээс нь Аудитын хороо, хараат бус гишүүд гээд бид бол та бүхний л төлөөлөл. Та бүхний саналыг хүлээж авахад нээлттэй шүү. Хараат бус гишүүдийн зүгээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд, ээлжит хуралд ч гэсэн санал гаргах бүрэн эрх нь нээлттэй байгаа.

Мөнгөнчимэг, Хурлын дарга: Хуулийн газрын захирал, яг хууль эрх зүйн талаасаа нэмэлт тайлбар өгөр үү?

Б.Амарсанаа, Хуулийн газрын захирал: Хувьцаа эзэмшигч Энхбаярын тавьсан асуулттай холбоотой нэмэлт байдлаар хариулахад, ТУЗ-ийн дарга бас хариуллаа. Жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийн асуудлыг хууль тогтоомжид Компанийн тухай хуульд харшлаагүй тохиолдолд дүрэмдээ тусгайлан заах боломжтой. Тэгэхээр энэ хяналтын зөвлөлийн төлөөлөлтэй холбоотой асуудлыг бол компанийн дүрэмд тодорхой заагаад оруулаад хэрэглэх бас боломжууд байгаа.

Мөнгөнчимэг, Хурлын дарга: Заалнаас өөр санал байна уу? Саяны асуудалтай холбоотой, 5 хувь гэдэг асуудал Компанийн тухай хууль дээрээ нэг ийм зөрчилтэй, яг бодит байдал дээр 5 хувиас дээш хувь гэдэг нь боломжийг нь хэр бүрдүүлж байгаа юм. Жишээ нь, одоо манай Төрийн банкн дээр 5.71 хувьтай байгаа учраас, энэ нь нэлээн өндөр ийм шалгуур юм аа гэж байна. Хууль эрх зүйн хоорондын уялдаа холбоог сайжруулах тал дээр, өчигдрийн Хөрөнгийн

биржийн хурал дээр ч гэсэн энэ асуудлууд бас яригдаж байсан. Үүнийг ЗГ, УИХ-ын түвшинд эргэж харах ёстой юм байна аа гэж бодож байгаа. Энэ талын саналыг ч гэсэн Сангийн яамны зүгээс хэлээд явна гэж харж байгаа. Дээр нь Хууль зүйн сайдаас Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хууль бас өргөн баригдаад явж байгаа. Энэ нь хэлэлцэгдээд явах юм бол, хуулийн зарим нэг заалтууд, шийдэгдэхгүй байгаа асуудлууд тус хуульд тодорхой тусгагдаад явах болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа. За ингээд заалнаас өөр асуулт байхгүй бол цахимаар асуулт байна уу? Цахимаар ирсэн асуулт байхгүй гэж байна. Ингээд хөтөлбөрийнхөө дагуу 4 дэх асуудал буюу “Төрийн банк” ХК-ийн ХЭХ-ын журмыг батлах тухай тогтоолын төслийг хэлэлцлээ. Энэ тогтоолын төсөлтэй, журамтай холбогдолтой асуулт хариултыг мөн заалнаас одоо бас авч хэлэлцлээ. Дараагийн 5 дахь буюу өнөөдрийн хурлын одоо хамгийн сүүлийн хэлэлцэх асуудал руугаа ороод явъя. “Төрийн банк” ХК-ийн ТУЗ-ийн ажиллах журам батлах тухай тогтоолын төслийг хэлэлцүүлнэ. Танилцуулгыг ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн дарга танилцуулна.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Төрийн банк ХК-ийн ТУЗ-ийн ажиллах журам батлах тухай танилцуулгыг хийв.

Мөнгөнчимэг, Хурлын дарга: Журмын төсөлтэй холбоотой санал заалнаас авъя.

Бадамсүрэн, Хувьцаа эзэмшигч: ТУЗ-ийн ажиллах журмын төсөлтэй танилцлаа. Үүн дээр 2-3 санал байна. ТУЗ-ийн гишүүн нь дараах эрх үүргийг хэрэгжүүлж ажиллана гээд ерөнхий орсон байна. Үүн дээр ТУЗ-ийн гишүүний эрх үүргийг тусад нь бүр шалгаж өгөөч ээ. Хувьцаа эзэмшигчид бас гишүүд бас биднийг төлөөлж байгаа ТУЗ-ийн гишүүд маань ямар эрх үүрэгтэй ажиллах юм гэдгийг тусад нь нэлээн дэлгэрэнгүй задалж өгмөөр байна. Энэ үүргийнхээ дагуу ажиллаж чадаж байна уу гэдгийг хяналтын зөвлөл болоод хувьцаа эзэмшигчид бас эргээд хяналт тавихад нээлттэй, тодорхой байх нь байна, гэж харж байна. За дараагийн асуулт нь, ТУЗ-ийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнахтай холбоотой заалт байна. Үүн дээр ТУЗ-ийн жилийн төлөвлөгөөг оны өмнө гаргана, тайланг ТУЗ-ийн хуралд танилцуулна гэж явсаар байгаад хамгийн сүүлийн 7.7 дээр ээлжит хурал дээр бүх гишүүддээ тайланг цахимаар мэдээлнэ гэсэн байна. Тайлагнах мэдээлэх 2 чинь шал өөр, мэдээлнэ гэдэг чинь зүгээр ТУЗ ийм ажил хийсэн гэдгээ цахимаар ч юм уу, интернэт орчинд юм уу, тэр хурал дээр мэдээлэх гээд байна л даа. Гол нь тайлангаа тавиад гишүүддээ энэ ажлаа танилцуулаад, эндээсээ үнэлэлт, дүгнэлт авдаг байвал ямар вэ гэдэг дээр, энийг жоохон дэлгэрүүлж өгөөч ээ гэж хэлэх гэсэн юм. 2 дугаарт, ТУЗ-ийн гишүүдийг ямар хугацаатай ажиллуулах юм гэдэг нь энэ журамд байхгүй байна. Компанийн дүрэмд байгаа юм болов уу? Сангийн яамнаас дээрээс нь Монголбанкнаас ТУЗ-ийн гишүүнд хэд хэдэн хүн томиллоо гээд ингээд яваад байх юм уу? Ямар хугацаатай ажиллах хүмүүс вэ? Энэ дээр энэ журам дээрээ ТУЗ-ийн гишүүдийг тэдэн жил ажиллана, тэдэн гишүүнтэй байна, тэдэн жилийн хугацаанд тэдээс доошгүй гишүүдийг нэмж өөрчилж шинэчилж байна аа гэсэн ийм нэг саналыг бас оруулбал ямар вэ, гэсэн ийм саналтай байна. За тэгээд хамгийн анхны 5 банкнаас хамгийн анх IPO гаргаад зарласан Төрийн банкны бас үйл ажиллагааг дэмжиж хувьцаа эзэмшигч болсон байгаа. Гэхдээ бусад компаниудыг бодоход одоо эндээсээ нэлээн түүчээлж, нэлээн манлайлж бас нэлээн хурдтай шаргуу ажиллаасай гэдгийг энэ хувьцаа эзэмшигчид бид нар бас хүлээж байгаа. Та бүхэнд амжилт хүсье ээ.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: ТУЗ-тэй холбоотой 1 дүгээр асуултын хувьд, ТУЗ-ийн гишүүдийн хийх ёстой ажил бүрэн эрх чиг үүрэгтэй холбоотой. Энэ нь 1 дүгээрт Компанийн

хуульд нэлээн олон ерөнхий заалтууд байдаг. Компанийн хууль, Банкны тухай хуульд хараат бус болон ердийн гишүүдийн бүрэн эрх, үүргийг тусгасан байгаа. Та бүхэн ойлгоорой, энэ журам бол гол нь үйл ажиллагааны журам шүү. Эрх үүрэг, дотоод харилцаатай холбоотой асуудлууд бол ороогүй. Манай компанийн бүртгэсэн дүрмийн 10.1 болон 10.13 дахь заалтад Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд зааснаас илүү дэлгэрэнгүй эрх, үүргүүд орчихсон байгаа. Энэ журам дээр таны асуусан 5.1.3-тай холбоотой, 5.1 дүгээр зүйлтэй холбоотой бүрэн эрх бол хуралд оролцохтой холбоотой байгаа. Энэ журам нь үйл ажиллагаатай холбоотой эрх үүргийн харилцааг зохицуулж байгаа. Тайлагнах гэдэг дээр хараат бус гишүүдийн хувьд 7.4 дээр ТУЗ-ийн хараат бус гишүүд нь өөрийн ажлын тайланг улирал бүр дараа сарын 15-ны өдрийн дотор эрх бүхий байгууллагаас баталсан журын дагуу гаргаж, Монголбанканд хүргүүлэх бөгөөд хагас жил тутамд олон нийтэд мэдээлнэ гэж байгаа. ТУЗ-ийн гишүүдийн хувьд бол банкны өмнөх ээлжит хурлаар баталсан дүрмээр бүрэн эрхийн хугацаа бол 3 жил гэж заасан байдаг. Энэ дүрмийнхээ дагуу үйл ажиллагаа явуулна. ТУЗ бол өөрөө бие даагаад бүрэн эрхээ шийдэхгүй. Дээрээс нь бас Монголбанкнаас төлөөлөл манай ТУЗ-д байдаггүй шүү.

Мөнгөнчимэг, Хурлын дарга: ТУЗ-ийн гишүүдийн талаар тайлбар хэлье. ТУЗ-ийн гишүүн дүрмийнхээ дагуу 3 жилээр сонгогдохоор байгаа. Гэхдээ энэ нь хөдөлгөөнгүй хугацаа гэсэн үг биш. Би бас өмнөх асуудлууд дээр ТУЗ-ийн гишүүдтэй холбоотой хэлж байсан. Сангийн яамны зүгээс, ЗГ-ын зүгээс бид олон нийтийн оролцоог одоо ил тод болгох оруулж ирэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах үүднээсээ ТУЗ рүү үе шаттайгаар төлөөллийг нь оруулаад явна аа гэдэг, ийм зарчмыг баримтлаад явж байгаа. За энэ удаагийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн дарга танилцуулсан. Банк, санхүүгийн чиглэлийн хүмүүс байгаа. За энэ хүмүүсээ яагаад энэ удаадаа сонгосон юм бол гэхээр Төрийн банк маань олон нийтэд нээлттэй болж байгаа IPO гаргаж байгаа, завсрын, шилжилтийн үед мэргэжлийн хүмүүс зөв чиг баримжаатай, тодорхой хэмжээний банкны үйл ажиллагаанд дэмжлэг тус болоод, хамт энэ шилжилтийг амжилттай хийж чадах байх гэдэгт итгэж сонгосон байгаа. Энэ ч утгаараа, системийн том 5 банкаас хамгийн түрүүнд IPO амжилттай гаргаад ингээд явж байна. Бид 5.71 хувиа нээлттэй болгочихсон байгаа, цаашлаад 20 хувь руу явна, 20 хувиасаа дээшээ явна. Энэ болгонд ТУЗ, банкны засаглалын асуудал дээр Та бүхний оролцоог нэмэгдүүлэх, оролцоог хангах тал дээр анхаарч ажиллана гэдгийг Та бүхэнд, хувьцаа эзэмшигчдэдээ нэмэлтээр хэлье. За ингээд өөр заалнаас асуулт байна уу? Энэ журамтай холбогдолтой цахимаар асуулт байгаа юу? Байхгүй бол бид өнөөдөр хэлэлцэх ёстой 5 асуудлаа амжилттай хэлэлцэж, танилцах 3 асуудалтайгаа танилцаж дууслаа.

Мөнгөнчимэг, Хурлын дарга: Та бүхэн саналаа өгнө үү. Ингээд хөтөлбөрийнхөө дагуу 20 минутын завсарлагыг авъя. За энэ 20 минутын завсарлагын дундуур Тооллогын комисс, Та бүхний өгсөн саналыг нэгтгэх тооллогыг нэгтгэх, тооллогын комиссын үйл ажиллагааг албажуулах процессын ажил хийгдэх учраас 20 минутын дараа 13 цаг 20 минутад эргээд энэ зааландаа цуглая.

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Өөрийн саналаар Тооллогын комисст хөндлөнгөөс ажиглагч хийж, хяналт тавих 2 хүнийг урьж байна. Та бүхэн утсаар хэрхэн санал өгөх талаарх видео зөвлөмжтэй танилцана уу. Тооллогын комиссын зүгээс видео зөвлөмжийг танилцуулав.

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Завсарлагын цаг дууслаа. Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга А.Батмөнхийг индэрт урьж байна.

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Санал хураалтын дүн, Тооллогын комиссын тогтоолыг дараах байдлаар танилцуулав.

1. “Төрийн банк ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 94.97% ирцтэйгээр, 99.987% зөвшөөрсөн санал өгсөн байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцов.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
717,035,867	99.987 %	95,740	0.013 %	0	0.000 %

2. “Төрийн банк” ХК-ийн Хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 94.93 % ирцтэйгээр, 99.982% зөвшөөрсөн санал өгсөн байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцов.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
716,737,390	99.982 %	40,336	0.006 %	91,111	0.013 %

3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 94.911% ирцтэйгээр, 99.967% зөвшөөрсөн санал өгсөн байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцов.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
716,435,660	99.967 %	42,431	0.006 %	190,746	0.027 %

4. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батлах асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 94.90% ирцтэйгээр, 99.969 % зөвшөөрсөн санал өгсөн байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцов.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
716,363,059	99.969 %	214,972	0.030 %	5,556	0.001 %

5. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн батлах асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 94.90% ирцтэйгээр, 99.97% зөвшөөрсөн санал өгсөн байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцов.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
716,368,337	99.970 %	126,454	0.018 %	88,796	0.012 %

С.Мөнгөнчимэг, Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан 5 тогтоолын төслийг тус тус уншиж танилцуулан хурлыг хааж, алх цохив.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлав.

1.1 “Төрийн банк” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд “Грант Торнтон Аудит” ХХК-ийн хийж баталгаажуулсан аудитын тайлан, түүний талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрөв.

2. “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж компанийн гаргасан 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 755,096,250 (долоон зуун тавин таван сая ерэн зургаан мянга хоёр зуун тавь) ширхэг энгийн хувьцаан дээр 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 134,903,750 (нэг зуун гучин дөрвөн сая есөн зуун гурван мянга долоон зуун тавь) ширхэг энгийн хувьцааг олон нийтэд үе шаттайгаар нэмж гаргахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д зөвшөөрөв.

2.1 “Төрийн банк” ХК-ийн нэмж гаргаж буй 134,903,750 (нэг зуун гучин дөрвөн сая есөн зуун гурван мянга долоон зуун тавь) ширхэг хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг тус компанийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэв.

2.2 Нэмж гаргах энгийн хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалахаар тогтов.

2.3 Хувьцаа нэмж гаргахтай холбоотойгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д даалгав.

2.4 Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу “Төрийн банк” ХК-ийн энгийн хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан олон нийтэд үе шаттайгаар гаргах төлөвлөгөөг банкны дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д даалгав.

2.5 Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д нэмж гаргасан хувьцааг бүртгүүлэх, арилжаалах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах зэрэг шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/, Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д үүрэг болгов.

2.6 Нэмж гаргах хувьцааг зохих журмын дагуу үе шаттайгаар олон нийтэд санал болгон “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан амжилттай арилжаалсан тохиолдолд шаардлагатай асуудлыг хэлэлцүүлэхээр Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д үүрэг болгов.

2.7 Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д даалгав.

3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалтыг нэмэв:

1/2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг:

“2.6. Энэ журмын 2.4.4 дэх заалтад заасны дагуу Хяналтын зөвлөлийн гишүүний цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 (хоёр) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс илүүгүй хэмжээгээр тогтооно.”

2/2 дугаар зүйлийн 2.4.5 дахь заалт:

“2.4.5. Энэ журмын 2.4.3 дахь заалтад заасны дагуу нэр дэвшигч бүрээр дүгнэлт гаргахад Хяналтын зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлэх хүсэлт ирээгүй, эсхүл Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь журмын 2.2 дахь хэсэгт заасан шаардлага хангахгүйн улмаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлэх Хяналтын зөвлөлийн гишүүний тоо 7 (долоо)-д хүрэхгүй тохиолдолд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулалтын хугацааг 10 (арав) хоногоор сунгаж, хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дахин мэдэгдэнэ.”

3/2 дугаар зүйлийн 2.4.6 дахь заалт:

“2.4.6. Энэ журмын 2.4.5 дахь заалтад заасны дагуу сунгасан сонгон шалгаруулалтын хугацаанд нэмэлт хүсэлт ирээгүй, эсхүл Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь журмын 2.2 дахь хэсэгт заасан шаардлага хангахгүйн улмаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлэх Хяналтын зөвлөлийн гишүүний тоо 7 (долоо)-д хүрэхгүй тохиолдолд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцож, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна.”

4/2 дугаар зүйлийн 2.4.7 дахь заалт:

“2.4.7. Энэ журмын 2.4.6 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцсон тохиолдолд Хяналтын зөвлөлийн гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хуралд нэр дэвшүүлэх сонгон шалгаруулалтыг явуулна.”

3.1 “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын 4 дүгээр зүйлийн 4.11 дэх хэсгийн “гэмдэглэлд” гэсний дараа “хуралд оролцсон” гэж, мөн зүйлийн 4.10.4 дэх заалтын “шийдвэрийг” гэсний дараа “хуралд оролцож буй” гэж тус тус нэмэв.

3.2 “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.4.1 дэх заалтын “80 (ная)” гэснийг “100 (зуу)” гэж, мөн зүйлийн 2.4.3 дахь заалтын “50 (тавь)” гэснийг “70 (дал)” гэж тус тус өөрчлөв.

3.3 “Төрийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад, нээлттэй мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Уянга/-д үүрэг болгов.

4. “Төрийн банк” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам”-ыг шинэчлэн батлав.

4.1 Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Төрийн банк” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 01/1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцов.

4.2 “Төрийн банк” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/, Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д тус тус даалгав.

5. “Төрийн банк” ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн батлав.

5.1 Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Төрийн банк” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 01/1 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцов.

5.2 “Төрийн банк” ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д даалгав.

ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.МӨНГӨНЧИМЭГ

Э.УЯНГА

**“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр:

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт хосолсон /танхим, зайнаас/ хэлбэрээр зохион байгуулагдана.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	“Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл			
2	“Төрийн банк” ХК-ийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох тухай тогтоолын төсөл			
3	“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл			
4	“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам батлах тухай тогтоолын төсөл			
5	“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажиллах журам батлах тухай тогтоолын төсөл			

2023 оны ... –р сарын ...-ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____
/ _____ /

Саналын хуудсыг бүртгэж, хүлээж авсан ажилтны гарын үсэг, гарын үсгийн тайлал:

/ _____ /

САНАМЖ

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) тэмдэглэгээг хийнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах "Төрийн банк" ХК-ийн Төв байр, орон нутаг дахь салбар нэгжүүдээр, цахим хэлбэрээр өгөх бол Төрийн банкны цахим хуудас /www.statebank.mn/-аар дамжуулан өгч болно.
3. Хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгсөн бол дахин санал өгөх эрхгүй.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулж, итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
5. Засварласан, балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
6. Хэлэлцэх асуудалтай холбогдох асуулт, саналаа арын нүүрэнд бичиж өгнө үү.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцох эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал:

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан:

--oOo--

Хувьцаа эзэмшигчийн асуулт, санал: